

**Монгол Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар
сарын 15-ны өдөр (Мягмар гараг)-ийн
хуралдааны гар тэмдэглэл**

Байнгын хорооны дарга А.Бакей ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 45 минутад Төрийн ордны “А” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Батхүү, Д.Батцогт, Н.Батцэрэг, М.Батчимэг;
Тасалсан: Б.Наранхүү, С.Дэмбэрэл.

Нэг. Улсын Их Хурлын Тамгын газрын 2012 оны үйл ажиллагааны тайлан сонсох.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, мөн газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан Нарийн бичгийн дарга Н.Отгончимэг, Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан Нарийн бичгийн дарга Б.Цэвээнпүрэв, Дотоод аудитор Ц.Лхагвагэрэл, Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Дашдорж, орлогч дарга Н.Цогтсайхан, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Д.Одсүрэн, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Ц.Норовдондог, Хяналт үнэлгээний хэлтсийн дарга Л.Энхтуяа, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаг, Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв, Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Д.Энхтуяа, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх О.Тунгалаг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

Тайланг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Цог, Су.Батболд, Ж.Батзандан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Л.Цог, Су.Батболд, М.Энхболд, С.Баярцогт, Р.Бурмаа, Р.Гончигдорж, А.Бакей нар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын Тамгын газарт Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөхөөр тогтов.

Уг асуудлыг 11 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Зарим аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцсан дүн.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх О.Тунгалаг, Ж.Бямбадулам нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

Танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Р.Бурмаа уншиж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Су.Батболдын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, С.Баярцогт, Л.Цог, Ж.Батзандан, Х.Тэмүүжин, Р.Гончигдорж, Р.Бурмаа нар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь Байнгын хорооноос гаргах тогтоолыг хойшлуулах санал хэлэв.

Уг асуудлыг 12 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооноос хийх ажлын төлөвлөгөөний тухай.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх О.Тунгалаг, Ж.Бямбадулам нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

Төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

А.Бакей: - Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооноос хийх ажлын төлөвлөгөөг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

Гишүүдийн олонхын саналаар дэмжигдлээ.

Хуралдаан 12 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

А.БАКЕЙ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

М.НОМИНДУЛАМ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН НАМРЫН ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ 2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН 15-НЫ
ӨДӨР (МЯГМАР ГАРАГ)-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

А.Бакей: - Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төрийн байгуулалтын байнгын хороонд ирвэл зохих гишүүдийн ирц бүрдэж байна Сүхбаатарын Батболд гишүүн, Р.Гончигдорж гишүүн, Ч.Сайханбилэг гишүүн, Миеэгомбын Энхболд гишүүн, Р.Бурмаа гишүүд одоохон орж ирэх юм байна. Ирцэд бүртгэж бай гэсэн. Ингээд ирц бүрдэж байна. Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Ингээд өнөөдрийн хуралдаанаар гурван асуудал хэлэлцэнэ. Нэгдүгээрт, Улсын Их Хурлын Тамгын газрын 2012 оны үйл ажиллагааны тайланг сонсоно, хоёрт нь Зарим аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцсан дүнгийн тухай сонсож шийдвэр гаргана. Гуравдугаарт, Төрийн байгуулалтын байнгын хорооноос Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх ажлын төлөвлөгөө хэлэлцэж батална. Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудлыг баталъя гэсэн гишүүд гараа өргөнө үү?

10-аас 6.

Батлагдлаа. Ингээд асуудлаа дарааллын дагуу хэлэлцэж эхэлье.

Нэг. Улсын Их Хурлын Тамгын газрын 2012 оны үйл ажиллагааны тайлан сонсох.

Улсын Их Хурлын Тамгын газрын 2012 оны үйл ажиллагааны тайланг сонсоно. Энэ дээр хуулийн зарим тайлбарыг та бүхэнд танилцуулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д бол Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Төрийн байгуулалтын байнгын хорооны дүнг нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулж болно гэсэн ийм заалт байна. 42³.3 зүйл дээр бол Улсын Их Хурлын төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөн хуулийн 42³.2-т заасан төрийн аудитын байгууллагын дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэнэ гэсэн ийм тодорхой заалтууд байна. Ингээд хэлэлцэж байгаа асуудлаар та бүхэнд тайланг тараасан байгаа. Мөн санхүүгийн болоод аудитын тайланг эрхэм гишүүдэд тараасан байна. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж өнөөдрийн хуралдаанд дараах албан тушаалтнууд оролцож байна. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Б.Цэвээнпүрэв Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, Нийтлэг үйлчилгээ хариуцсан Нарийн бичгийн дарга, Н.Отгончимэг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан Нарийн бичгийн дарга, Ц.Лхагвагэрэл Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитор, Ж.Дашдорж Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн дарга, Н.Цогтсайхан Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн орлогч дарга, Д.Одсүрэн Улсын

Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга, Ц.Норовдондог Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Л.Энхтуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн дарга, Ц.Нарантунгалаг Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, Н.Ширэндэв Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга, Д.Энхтуяа Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга, Ж.Элбэгзаяа Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга гэсэн ийм хүмүүс оролцож байгааг та бүхэнд мэдэгдье. Ингээд Б.Болдбаатар даргыг тайлангаа товч танилцуулахыг урьж байна.

Б.Болдбаатар: - Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Сая А.Бакей дарга Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг хэлэлцдэг хууль зүйн үндэслэлийг хэллээ. Онцлог юм нь энэ дээр нэмж хэлэх юм нь юу гэхээр энэ тайлан маань 2012 оны үйл ажиллагааны тайлан байгаа. 2012 он маань Улсын Их Хурлын сонгуулийн жил байдаг. Нэг үгээр хэлбэл энэ жил өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа шинээр сонгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа хоёр юм Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааны уулзвар жил байсан гэдэг утгаараа онцлог жил байгаа. Тэгээд Тамгын газар нь Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд тайландаа 2012 оны хийсэн ажлын тайлан бол 2013 онд хийгдэж байгаа зарим өөрчлөлтүүдийг хамт тусгасан байгаа. Тайлангаа хуульд заасан хугацааны дотор 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн. Санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар оруулаад тэдний санал зөвлөгөө агуулаад хүргүүлсэн байгаа. Тайлант хугацаанд буюу 2012 онд Улсын Их Хурлын Тамгын газар нийт 271 хууль, үүнээс бие даасан 40 хууль, нэмэлт, өөрчлөлт оруулсан 182, хүчингүйд тооцсон 137, олон улсын гэрээ конвенц соёрхон баталсан хууль 12, нийт Улсын Их Хурлын 134 тогтоол, Байнгын хорооны 94, мөн Байнгын хорооны 407 санал, дүгнэлтийг боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө туслалцаа өгч ажиллаж ирсэн байгаа. Мөн батлагдсан хууль тогтоомжуудын эцсийн найруулгуудыг тогтоосон хугацаанд нь бэлтгэж Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж ёсчлуулсан.

Хууль, тогтоолын төсөл хэлэлцүүлэх явцад гишүүдээс гарсан нийтэд 1552 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Их Хурлын Тамгын газрынхан бичиж, хуульд заасны дагуу бүлэглэн нэгтгээд нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлж байсан. Мөн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн Байнгын хорооны танилцуулга 57 бичсэн байгаа. Хяналт шалгах үйл ажиллагаа, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд тайлангийн хугацаанд Улсын Их Хурлын захирамж, Байнгын хороодын тогтоолоор шалгалтын өмнөх болон танилцах ажлын чиглэлээр нийт 7 ажлын хэсэг байгуулагдаж 29 хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж танилцсан байгаа. Давхардсан тоогоор бол Улсын Их Хурлын 57 гишүүн 110 асуудлаар Засгийн газарт 32 удаагийн асуулга тавьсан байгаа. Мөн 20 гишүүн 78 асуудлаар Засгийн газарт 19 удаа бичгээр асуулт тавьсан ийм дүн гарсан байгаа. Энэ бүхнийг хэлэлцүүлэхэд холбогдсон ажлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж Тамгын газар ажиллалаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд нэгдсэн хуралдаан 74, Байнгын хороодын 250, дэд хороодын 6, нийт 330 удаагийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж явуулсан. Үүнээс 1590 хуудас товч тэмдэглэл, 8741 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлсөн байж байгаа. Байнгын хорооны хуралдааны нийт 245 цагийн бичлэгийг mp3 файлд хөрвүүлж орчин үеийн шаардлага технологийн шинэчлэлийн дагуу нийцүүлж хадгалж ирсэн байгаа.

Дараагийн ажлын хүрээ бол судалгаа, мэдээлэл, лавлагаа гаргах ажил байгаа. 2012 онд нийтдээ 68 судалгааны ажил хийгдсэн. Үүнээс Улсын Их Хурлын гишүүдийн захиалгаар 51 нь, судалгааны төвийн санаачилгаар 17 судалгаа хэрэгжсэн байж байгаа. Үүнээс аваад үзэх юм бол нийтдээ бодлогын судалгаа дүн шинжилгээ нь 20 хувь байгаа, харьцуулсан судалгаа бол 60 хувийн судалгаа гарсан байж байгаа. Тойм судалгаа, лавлагаа, мэдээлэл 20 гарсан ийм дүн гаргаж ирж байгаа юм. Тэгээд нийтдээ судалгааны ажлын 72.8 хувийг гишүүдийг захиалгаар, 27.2 хувийг судалгааны төвийн санаачилгаар хийж гүйцэтгэсэн ийм байж байгаа. Судалгаануудаа нэгтгээд “Бодлогын судалгаа шинжилгээ” гэсэн цуврал гаргаж явж байгаа. 2012 онд 12, 13 дугаар ботийг гаргасан. Энэ өнөөдрийн байдлаар бол 14, 15 дугаар ботийг гаргуулаад саяхан та бүхний гар дээр хүргүүлсэн байж байгаа. Мөн энэ хугацаанд Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба гэсэн номыг эмхэтгэн гаргаж харьцуулж судалгаа хийснийг гишүүдэд хүргүүлсэн байгаа. Мөн энэ хугацаанд Тамгын газрын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, Төрийн байгуулалтын байнгын хороогоор онол, практикийн бага хурал зохион байгуулж явуулсан байж байгаа.

2012 онд судалгаа шинжилгээний ажлын хүрээнд Түрк улсын хөгжлийн агент ТИКА-ийн шугамаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын номын санд өндөр хурдны хүчин чадалтай робот скайнерийг суурилуулсан байж байгаа. Энэ суурилуулсан скайнер ашиглаж 1954-2011 он хүртэлх Төрийн мэдээллийн эмхэтгэлүүдийг бүрэн хэмжээгээр скайнердаж цахим хэлбэрт хөрвүүлээд байгаа. Архив дээр энэ чиглэлийн ажлууд нэлээн хурдацтай явж байгаа.

Улсын Их Хурлыг сурталчлах, олон нийттэй харилцах үйл ажиллагааны чиглэл байж байна. Энэ тайлангийн хугацаанд нийтдээ 1100 гаруй дүрстэй мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулсан. 135 удаагийн хэвлэлийн бага хурал зохион байгуулах, 4 удаа хуулийн төслийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг зохион байгуулсан манай Тамгын газрынхан бэлтгэлийг хангаж оролцсон байгаа. Мөн түүнээс гадна энэ өмнөх хугацаанд Сансар кабелийн телевизээр Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг шууд дамжуулж үзүүлдэг байсныг өөрчилж, МҮОНТ-2 суваг, Юнивишн телевизтэй хамтраад Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг шууд дамжуулдаг болсон. Түүнчлэн өөрийн вэб сайтаар чуулганы хуралдааныг шууд дамжуулж явуулж байгаа. Юнивишнтэй хамтраад ухаалаг гар утсанд зориулсан программ гаргасан байгаа. Үүний дагуу дэлхийн хаана ч явсан чуулганы үйл ажиллагааг шууд ухрааж үзэж болох ийм боломжоор хангагдсан байж байгаа. Тайлангийн хугацаанд Төрийн мэдээллийн нийт 48 дугаарыг хэвлэж, бүх дугаарыг цахим хэлбэрт оруулсан байж байгаа. Мөн Төрийн мэдээлэл сэтгүүлийг цахим хэлбэрт оруулж ipad болон iphone хэрэглэгчээр

мөн дээр нь android үйлдлийн системийн гар эзэмшигчид үнэ төлбөргүйгээр авах боломжоор хангасан байгаа. Их Хурлын 2 вэб сайт ажилладаг. Энэ нь нэг нь parliament.mn, нөгөөдөх нь open.parliament.mn ийм 2 хуудас ажиллаж байгаа. Энэ 2 хуудсаар хуралтай холбоотой бүх мэдээ материалыг бэлтгэж гаргаж өгч явж байгаа. Мөн түүнчлэн олон нийтийн сүлжээний цахим хуудсууд байгаа facebook, twitter, youtube-ээр өөрсдийн үйл ажиллагааг бол сурталчлах ажлыг зохион байгуулан явуулж байна.

Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар 2012 онд нийтдээ Улсын Их Хурлын гишүүд олон улсын 58 бага хурал, арга хэмжээнд оролцсон ийм дүн гарсан. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүдийн гадаадын зочин төлөөлөгчтэй, олон улсын байгууллагын төлөөлөлтэй уулзах, уулзалтыг зохион байгуулах, уулзалт ярианы сэдвийг бэлтгэх, шаардлагатай лавлагаа материалыг гаргаж өгөх, хэлмэрчлэх, уулзалт ярианы тэмдэглэл хөтлөх гэх мэтчилэнгээр энэ мэргэжил арга зүйн зохион байгуулалтын туслалцааг үзүүлж ирлээ. Түрүүн би хэлсэн Улсын Их Хурлын санхүүгийн 2012 оны тайланг бол Улсын Их Хурлын Тамгын газраас бэлдэж Үндэсний аудитын газраар аудит хийлгэсэн байж байгаа. Нийтдээ 2012 онд Тамгын газар төсвийн урсгал зардалд Улсын Их Хурлын хэмжээнд 17 тэрбум 282.3 сая төгрөгийг санхүүжилт авах ёстой байсан. Үүнээсээ 15 тэрбум 132.4 сая төгрөгийн санхүүжилт авч 2.1 тэрбум төгрөгийн хэмнэлттэйгээр Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж ирсэн. Энэ хэмнэлт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 1 тэрбум 145 сая төгрөгөөс 1 тэрбум 124,4 сая төгрөгийн санхүүжилт худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан зохион байгуулж явуулсан. Нийт төсөвт зардлаас 20,6 сая төгрөгийг хэмнэж ажилласан байж байгаа. Энэ бол техникийн тодорхойлолт болон үнийн харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт баримталж ажилласны үр дүнд ийм хэмнэлт гаргасан байж байгаа. Тайлангийн хугацаанд нэг удаагийн буцалтгүй тусламжид бол 230,5 сая төгрөгийн, ар гэрт нь гачигдал тохиолдсон үед 9,7 сая төгрөгийн, эмчилгээний зардлын дэмжлэгт 79,4 сая төгрөгийн, шагнал урамшуулалд 32,6 сая төгрөгийн, ээлжийн амралтаараа орон нутагтаа амраад ирсэн ажилтанд 1,6 сая төгрөгийн замын зардлын хөнгөлөлт олгосон, ажилтнуудын нийгмийн асуудлыг сайжруулахад нь 50.0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн байж байгаа. Ингээд аудитын дүгнэлтээр манай Улсын Их Хурал бол санхүүгийн зөрчилгүй гэсэн ийм дүгнэлт гарсан байж байгаа.

Техник технологийн ажлын хүрээнд Улсын Их Хурлын даргаас үүрэг болгосны дагуу санал хураалтын системийн үндсэн 3 программ хангамжид нэмэлт, өөрчлөлтүүдийг шаардлагын дагуу цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн санал хураалтын картын дизайныг гаргаж, нөөцийн хамт зориулалтын хэвлэгчээр хэвлэж, программчлан ашигласан байж байна.

Мөн Их Хурлын үндсэн цахим хуудасны ухаалаг утас, хөдөлгөөнт төхөөрөмжүүдэд зориулагдсан хувилбарууд хийгдэж Apple компанийн App store, Google-ийн Play дээр тавиулсан байж байгаа. Үүнийг хэрэглэгчид татаж авч ухаалаг гар утас, хөдөлгөөнт интернетийн төхөөрөмжид суулгаж ашиглах боломжтой болсон. Түрүүн би давхар ярьсан байгаа. Дотоод сүлжээний мессенжер программ

нэвтрүүлсэн. Ингэснээр гаднаас хамааралгүйгээр дотооддоо мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжтойгоор мэдээлэл материалаа дамжуулж явуулах ийм боломж нээгдсэн байж байгаа.

20 орчим нэр төрлийн 320 гаруй техник хэрэгслийг засварлан байж байгаа, үүний дагуу хэвийн ажиллагаанд оруулсан, интернэтийн хурдыг 40 мб\с болгож өөрчилсөн, Цахим шуудангийн micro soft out looking лицензтэй программ хангамж худалдан аван нэвтрүүлж мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байна.

2012 онд Тамгын газар 210 нэгжийн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байсан, бүтээгдэхүүний 7 ангид 35 төрлийн 71 нэрийн бүтээгдэхүүн нийлүүлж, үр дүнгийн гэрээ байгуулж ажиллуулсан үр дүнтэй гарсан байж байгаа. 44 ажилтанд зэрэг дэв олгох болон зэрэг дэв ахиулах ажлыг зохион байгуулсан. Төрийн захиргааны болон мэргэжлийн шалгалтад тэнцсэн 11 ажилтныг тангараг өргүүлж, тухайн албан тушаалд нь томилон ажиллуулсан байна. Мөн 13 ажилтанд төрийн албаны нэмэгдэл олгох шийдвэр гаргаж хэрэгжүүлсэн байгаа.

2012 онд Тамгын газрын ажилтнуудаас БНХАУ, АНУ, Энэтхэг зэрэг улсад 3 хоногоос 3 сарын хугацаатай 57 ажилтан гадаадад танилцах аялал, сургалтад, мөн давхардсан тоогоор 104 ажилтан дотоодын сургалт, семинарт оролцож ирсэн байж байгаа. Тамгын газрын ажилтнуудаас 6 ажилтан 2012 онд төрийн дээд шагналаар, 9 ажилтан салбарын тэргүүний ажилтан цол, тэмдгээр, 3 ажилтан байгууллагын өргөмжлөл, мөнгөн шагналаар, 39 ажилтан мөнгөн шагналаар тус тус шагнагдсан. 2012 оны үр дүнгийн гэрээний биелэлтийн дүнг нь харгалзан 0.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг нийт ажилтнуудад олгосон ийм үр дүнтэй гарсан байна. Энэ бол 2012 онд хийсэн ажлууд байж байна.

2013 он гарснаар Улсын Их Хурлын гишүүдээс даалгасан Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл дээр хэлэлцүүлсний дагуу бол Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн баталсан байж байгаа. Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын Тамгын газрын дүрмийг баталсан тогтоолд заасны дагуу бол Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлөөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж Тамгын газрын бүтцийг 2013 оны 3 дугаар сарын 6-ны өдөр баталсан байж байгаа. Энэ бүтэц орон тоогоор бол Байнгын хороодын үйл ажиллагааг илүү тогтвортой хангах, түүнд үйлчилж байгаа ажлын албадын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Тамгын газрын бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн. Үүний дагуу бол Хууль зүйн үйлчилгээний шинэ хэлтсийг бий болгосон. Тэр нь Байнгын хороодын ажлын алба, Эрх зүйн экспертийн алба гэсэн хоёр үндсэн бүтэцтэйгээр ажиллаж байна. Хуулийн зөвлөхүүдийг өмнө нь хэлтсийн даргын хуваарилагдсан төсөл дээр ажилладаг байсан бол одоо Байнгын хорооны ажлын албатай харьяалагдаж ажиллаж байгаа. Асуудлынхаа чиглэлийн хүрээнд Байнгын хорооны даргатай хамтарч ажиллах, төсөл дээрээ баг болж ажиллах, ажлын зохион байгуулалтыг шуурхай хийх талаар ач холбогдолтой гэж үзсэн бөгөөд энэ талаар ч нэлээн ахицтай үр дүнтэй өгч байгаа гэж үзэж байна.

Байнгын хорооны ажлын албанд хуулийн зөвлөхөөс гадна тухайн салбараар мэргэшсэн мэргэжлийн зөвлөх, референтүүд ажиллаж байгаа. Эрх зүйн экспертийн

алба өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаар бол хууль зүйн зөвлөмж гаргах ажлыг шинээр хийж эхлүүлж байгаа. Одоогоор нийтдээ 12 хуулийн зөвлөмжийг гаргаж Байнгын хороодод албан бичгээр хүргүүлсэн байж байгаа. Чуулганы хуралдааны дэгийн талаар хоёр ч тайлбар бэлтгэж өгөөд явж байгаа.

2013 оны өнөөдрийг хүртэл хугацаанд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг хянах журмыг шинэчилж баталсан. Их Хурлын даргын захирамжаар баталж мөрдүүлж байна. Ингэснээр шат шатандаа тавих хууль тогтоох үйл ажиллагааны хяналтыг тодорхой болгож үүрэг хариуцлагыг сайжруулж өгсөн байж байгаа.

Улсын Их Хурлын гишүүдээс хэлэлцүүлгийн явцад гардаг шүүмжлэлтэй холбогдуулж энэ дээр нэлээн том өөрчлөлтийг хийсэн гэж үзэж байгаа. Энэ оны 3 сард НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтраад “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” гэсэн 2 төслийг хэрэгжүүлж явуулж байна. Энэ үйл ажиллагааны хүрээнд бид нарын Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төвийн үйл ажиллагааг шинэ зохион байгуулалтад оруулах, Улсын Их Хурал иргэд сонгогчдын хоорондох харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор ажлуудыг явуулж ирлээ.

Эхний шатны ажлууд нэлээн хангагдаад өнөөдрийн байдлаар нутгийн өөрөө удирдах байгууллагын хүрээнд орон нутгийн бүх иргэдийн Хурлын хүрээнд сургах сургалтын үйл ажиллагаа явагдаж байна. Шинэчилсэн бүтцээр хуучин 210 хүнтэй байсан бол 197 болгож орон тоогоо цөөрүүлсэн байгаа. Өнөөдрийн байдлаар 187 ажилтан ажиллаж байна. Үүнээс докторын зэрэгтэй 5, магистр 70, бакалаврын зэрэгтэй 187 хүн ажиллаж байна. Мэргэжлээр нь ангилвал Эрх зүйч 43.9 хувь, Эдийн засагч 19.2 хувийн ийм хүмүүс ажиллаж байгаа.

Энэ шинэчилсэн бүтцээр Мэдээлэл, технологийн хэлтсийг Программ хангамжийн алба, техник хангамжийн алба гэсэн 2 үндсэн бүтцээр ажиллаж байна. Улсын Их Хурлын даргаас гаргасан уриалгыг дэмжиж оюуны өмчийн зөрчилгүй программ хангамж ашиглах талаар нэлээн хэдэн үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд энэ 2013 ондоо багтаад бид нар Нээлттэй эхийн программ хангамжийг Тамгын газарт хэрэгжүүлж байна. Энэ программ хангамжийг хэрэгжүүлснээр бид нар нэг жилийн хугацаанд 500-аад орчим сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон. Хоёрдугаарт гэвэл ямар нэгэн байдлаар программ хангамжгүй гэсэн ийм хуулийн зөрчилгүй оюуны өмчийн эрх зүйн зөрчсөн ийм үйлдэл гаргахгүй болж төрийн байгууллагуудад үлгэр болсон гэж үзэж байгаа. Энэ туршлагаа Улсын Их Хурлаас томилогддог болон үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагууд тэр талаар туршлага солилцож ажиллаж байгаа.

2013 онд хийгдсэн шинэ бүтцээр бол дотоод аудитор нэгжийг шинээр бий болгосон, ингээд аудитор бол 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн уялдаа холбоог хангах, явцын гүйцэтгэлийн тайланг гаргах чиглэлээр ажил зохион байгуулж байна. Үүний хүрээнд дотоод аудиторын явуулж байгаа чиглэлээр бол санхүүгийн үйл ажиллагаагаа зохицуулж явуулах ажлуудыг цаг тухайд нь хийж

явуулж байгаа.

Улсын Их Хурлын хянах, шалгах функцийг сайжруулах зорилгоор Тамгын газрын бүтцэд Хяналт, шалгалтын хэлтсийг шинээр зохион байгуулсан. Энэ хэлтэс нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих алба, төсвийн шинжилгээний хэсэг гэсэн хоёр албатайгаар ажиллаж байгаа. Ийм чиглэлээр ажиллаж байгаа, төсвийн шинжилгээний ажил бол өнөөдрийн байдлаар хүмүүсээ бүрдүүлээд ажиллах юмыг Төрийн албаны тухай хуулийн дагуу зохион байгуулж явуулж байна. Товчхон ярихад ийм байна.

А.Бакей: - Б.Болдбаатар даргад баярлалаа. Ингээд тайлантай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Л.Цог гишүүн, Су.Батболд гишүүн, Ж.Батзандан гишүүн өөр? Ж.Батзандан гишүүнээр асуултыг тасаллаа. Л.Цог гишүүн асууя.

Л.Цог: - Тамгын газрынхаа тайланг сонсож байгаа юм байна гэж ойлголоо, хожуу ирсэн учраас. Тэгээд аливаа парламентын арын алба тогоо болсон энэ албанаас хамаг юм шалтгаалж байгаа шүү дээ, бидний үйл ажиллагаа. Тэгэхээр сая ингээд сонгуулийн дараа баахан орон тоо цомхтгоод өөрчлөх шиг боллоо. Хэдэн хувь нь өөр болов хуучин бүрэлдэхүүнээсээ? Үүнийг асуумаар байна. Хоёрдугаарт энэ цалин хэд байна, манайхны дээд, цалин хэд вэ? Мөд нэмсэн үү? Гуравдугаарт, намын бүлгүүдийн ажлын албатайгаа хэр уялддаг вэ? Манай ажлын алба гээд нэг алба байна, хэр дэм туслалцаа үзүүлдэг юм бол бид сайн мэдэхгүй байна. Бид аминдаа голоод байгаа, Тамгын газраасаа янз бүрийн дэм авч чаддаг юм уу бүү мэд. Нэг ийм бодол байна. Дараагийн юм бол би энэ албыг хашиж явсан л хүн. Төсөв маань энэ жил хэр өсөж байна, дутаж байгаа юм байна уу, дэмжлэг авах юм байх болов уу? Эртхэн хэлж байхгүй бол болдоггүй юм байгаа шүү дээ. Бодитой хэлбэл сайн байна л даа бидэнд.

А.Бакей: - Б.Болдбаатар дарга хариулъя.

Б.Болдбаатар: - Яг батлагдсан орон тоогоороо бол уг нь 227 хүн гэж байгаа, яг ажиллаж байсан хүн 210 байсан. Үүнээсээ бид нар 197 хүний орон тоо авч ажиллахаар ингээд бүтэц зохион байгуулалтаа шинэчилсэн. Өнөөдрийн байдлаар 187 хүн ажиллаж байгаа. Тэгэхээр ерөнхийдөө хуучин бүрэлдэхүүн, цоо шинээр өмнө ажиллаж байгаа хүн орсон гэвэл манай дээр 5 хүрэхгүй хувь нь л шинэчлэгдсэн дээ. Хуучин бүтэц бүрэлдэхүүнээ хадгалж үлдсэн байж байгаа. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс дээр бол мэргэжлийн сурвалжлагч, оператор авах дээр өөрчлөгдөж шинэчлэгдсэн байгаа. Бусад нь харьцангуй гайгүй ер нь хуучнаараа л ажиллаж байгаа. Цалин бол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сүлжээгээр цалинжиж байгаа. Манайх өөрсдөө нэмээд цалинжуулах юм бол хуулиар хязгаарлагдсан байж байгаа. Дундаж цалин бол 600-700 мянган төгрөг авч байгаа даа. Доктор, удаан жилийн нэмэгдэлтэй гээд авах юм ганц нэг хүн 1 сая орчим төгрөгийн цалин руу дөхдөг тийм юм байгаа. Яг цалингийн хувьд Улсын Их Хурлын Тамгын газар гишүүдэд хамгийн ойр үйлчилдэг ийм байгууллага байгаа, хууль тогтоох үйл ажиллагаанд хамгийн их оролцоотой ийм хүмүүс байдаг. Бидний явуулж байгаа үйл ажиллагаанаас хууль тогтоох үйл ажиллагаа шууд хамаардаг гэдэг утгаараа энд маш өндөр зэрэглэлийн

мэргэжилтэй боловсон хүчин ажиллах шаардлагатай. Тэр дундаа хуульч, эдийн засагч чиглэлийн мэргэжилтэй хүмүүс ажиллах шаардлага байдаг. Өнөөдөр Тамгын газрын маань ажиллаж байгаа хуульч, эдийн засагчид маань үнэхээр бусад хуульч, эдийн засагчидтай харьцуулах юм бол цалингийн хувьд үнэхээр бага авч байгаа. Ер нь бол яг үнэндээ хэлэхэд жирийн нэг өмгөөлөгч ажил хийгээд явахад бол бүрэн боломжтой хүмүүс өөрийнхөө санаачилгаар ажиллаж байна гэдэг бол иймэрхүү л хэмжээнд байгаа. Намын бүлэгтэй үйл ажиллагааг байнга уялдуулж явж ирдэг. Чиглэл чиглэлээрээ, нэгдүгээрт хуралдаан байгуулах чиглэлээр намын бүлэгтэй бид нар хамтарч ажиллаж байгаа. Ирц бүрдүүлэх асуудал дээр намын бүлгийн ажлын албагүйгээр бид нар хуралдааны ирцийг бүрдүүлэх туйлын бага байгаа, тэгэхээр бид нар намын бүлэгтэй хамтарч ажиллах шаардлагатай байдаг. Намын бүлгийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр гурван бүлэгтэйгээ санаа бодлоо солилцсон. Ер нь техник хэрэгсэл, материаллаг баазын хувьд бүрэн хангагдсан гэж үзэж байгаа. Тамгын газрын компьютерийн хангамж энэ жил нэлээн сайн байгаа шүү дээ. Бид нар БНХАУ-аас техникийн туслалцаа авсан байж байгаа. Дээрээс нь сая төсвийн хөрөнгө оруулалтаар бас 100 гаруй компьютерийг шинэчлээд явчихсан байгаа. Тэгэхээр Тамгын газар компьютер, техник хэрэгсэл хангалттай байгаа. Намын бүлэг маань өөрөө төсөвтэй учраас төсвийнхөө хүрээнд үйл ажиллагаагаа зохицуулаад хүмүүсийн шаардлагатай зүйлийг шийддэг ийм боломжтой чиглэлээр явуулж байгаа. Тамгын газраас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд манай намын бүлгүүд идэвхтэй оролцож байгаа. Олон нийтийн ажлууд, сургалт, мэдлэг боловсрол сайжруулах ажлуудаар Тамгын газраас намын бүлгүүдийн ажлын албыг татан оролцуулах, урьж оролцуулах ийм чиглэлээр явуулж байгаа.

2014 оны төсвийг бид нар өнгөрсөн 4 сараас хийж боловсруулж эхэлсэн. Тамгын газрынхаа холбогдох нэгжүүдээс санал авсан. Намын бүлгүүдээс авсан. Байнгын хороодоос санал авсны үндсэн дээр ирэх жилийн төсвийг боловсруулсан. Төсвийн байнгын хороогоор оруулаад Сангийн яаманд хүргүүлсэн. Нийтдээ ирэх жилийн төсөв бол энэ жилийнхээсээ 22.3 тэрбум төгрөг болж 3.6 тэрбумаар өсөж байгаа. Тэр нь голцуу хөрөнгө оруулалт байгаа. Урсгал зардал бол бид нар яг энэ 2012 оны түвшинд хадгалсан, цалин бол хэвээрээ, томилолт бол хэвээрээ байж байгаа. Хөрөнгө оруулалтыг нэмсэн, хөрөнгө оруулалт дээр юу нэмэгдэж байна вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүдийн ажиллаж байгаа орчин тавилгыг сайжруулах зорилтоор бол тавилгуудыг шинэчилье гэсэн ийм мөнгө оруулсан байж байгаа. Мөн Улсын Их Хурлын Тамгын газрын болоод Улсын Их Хурлын гишүүдийн чийрэгжүүлэх танхимыг шинэчилж тоноглоё гэсэн ийм юмнууд орж ирж байгаа. Мөн Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг дээрээс нь нэмээд Байнгын хороодын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор техник технологийн шинэчлэл хийх ийм чиглэлийн төсөл хэрэгжүүлж ажиллаж явж байна. Хэрвээ олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа нөхцөлд цаг хугацаандаа хэрэгжих энэ мөнгө маань улсын төсвөөс хэмнэгдэх ийм боломжтойгоор төсвийн төлөвлөлтийг хийгээд явж байгаа.

Дээр нь нэмэгдээд хаягдсан нэг юм байдаг. Он удаан жил дамжиж явдаг Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын орон сууцны нөхцөлийг сайжруулах мөнгө гэхэд жаахан 250 сая төгрөг байгаа. Үүнийг тавьсан байгаа, тэгээд үе үеийн парламентын гишүүд Их Хурлын мөнгөнөөс үүнийг хасчихдаг юм.

Тэгээд дагаад манай Их Хурлын Тамгын газрынхан тийм хэмжээний дэмжлэг авч чадахгүй хоцорчихдог тийм тал байгаад байгаа юм. Энэ дээр та бүхэн маань бас дэмжиж өгөөрэй гэдгийг л хүсэх байна.

А.Бакей: - Сундуйн Батболд гишүүн.

Су.Батболд: - Мэдээж жил болгон Улсын Их Хурлын Тамгын газрын тайланг сонсдог л доо Төрийн байгуулалтын байнгын хороон дээр. Бид нар энэ ажлын алб хэрхэн яаж ажиллаж байгаа юм, цаашдаа юун дээр анхаарах юм бэ гэдэг зүйл дээр ярилцдаг уламжлалтай. Тэгээд энэ шинэ парламентын бүрэн эрхийн хугацаа бүрэлдэж эхлээд бид нар анх удаа сонсож байх шиг байна. Яах вэ, би өдөр тутмын үйл ажиллагаанд нь оролцохгүй юм л даа яг ямар явж байгааг нь мэдэхгүй. Би хэдэн зүйлүүдийг бодлогын хэмжээнд асуумаар байгаа юм. Б.Болдбаатар гээд шинээр томилогдсон залуу хүн сайн ажиллана байх гэж бодож байгаа, сайн ажиллаж байгаа байх. Би ер нь Улсын Их Хурлын Тамгын газар гэдэг энэ бүтэц маань Улсын Их Хурлын даргад үйлчилдэг бүтэц үү, эсвэл энэ Улсын Их Хурлын 76 гишүүнд үйлчилдэг бүтэц үү гэдгийг та юу гэж бодож явдаг юм бэ? Яг үнэхээр та бүхэн маань 76 хүнд жигд хууль тогтоох үйл ажиллагаа явуулахад нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж чадаж байна уу, үгүй юу? Чадаж байгаа бол чадаж байгаа, чадахгүй байгаа бол юунаас болоод ийм байдалд хүрч чадахгүй байна вэ гэдгийг тодорхой хэлээч.

Хоёрдугаарт, Тамгын газрын хувьд ер нь яах вэ дээ, Улсын Их Хурлын гишүүн гэдэг чинь хүн харахад их л том дарга хүн л дээ, энэ хүмүүс бүгдийг мэддэг байх гээд л хүмүүс хараад тэгж боддог юм шиг байгаа юм. Яг хэрэг дээрээ Улсын Их Хурлын гишүүн гэдэг чинь хөөрхий амьтан нэг туслах, нэг зөвлөх тэгсхийгээд байдаг шүү дээ. Улсын Их Хурлын гишүүнээс өмнө их том дарга хийж байгаад ирсэн хүмүүс байдаг байх л даа. Тэгээд нэг жижигхэн өрөөнд орчихоод хажууд нь ганц хүүхэд суучихаад тэгээд юун ороод ирэв яав гэсэн байдалд хүрдэг хүмүүс байдаг л байх. Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газар гээд 200 гаруй хүнтэй бүтэцтэй ийм том юу байж байгаа л даа, би шинээр сонгогдсон гишүүдэд энэ талын зовлон байдаг болов уу гэж бодож байна. Энэ бүтэц тэр Улсын Их Хурлын гишүүн түүний хажууд байгаа зөвлөх, туслахуудад хэр зэрэг үйлчилгээ үзүүлж ханддаг юм бэ? Би зүгээр ингээд харж байхад манай Улсын Их Хурлын Тамгын газрын зүгээс тэр Улсын Их Хурлын зөвлөх, туслахуудыг эд нар яах вэ дээ хүн дагаад ирчихсэн хэдэн хүн байдаг юм гэсэн байдлаар хандах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхээсээ илүү ад үзэх, та нар бол ер нь улс төрийн албан тушаалтныг дагаж яваа хүмүүс болохоос энэ төрийн бодлого ажилд огт хамаагүй шүү гэсэн байдлаар хандах ч юм уу, тэд нарын үгийг үл тоох, заавал ч үгүй араас нь гишүүд нь ямар нэгэн хүсэлт тавилаа гэхэд гишүүд нь араас нь утасддаг юм уу, очиж байж асуудал нь шийдвэрлэгддэг ч юм уу, иймэрхүү байдлаар хандах хандлага байдаг юм л даа. Энэ дээр та нар ахиц дэвшил гаргаж байгаа юу? Энэ хүмүүсийг тэр Улсын Их Хурлын бүтцэд оруулах тал дээр нь хэр зэрэг ямар ажил зохион байгуулж байгаа юм бэ? Миний дараагийн үүнтэй холбоотой асуудал нь Улсын Их Хурал дахь бүлгүүдийн үйл ажиллагаа бас байгаа. Бүлгүүдийн ажилтан, албан хаагчдын цалин хангамж, хөлс бусад үйл ажиллагаатай холбоотой явдал нь Тамгын газрын бүтцээс огт өөр тусдаа юм шиг тийм хандлага ажиглагддаг. Тэгэхээр ийм Улсын Их Хурлын

Тамгын газар бүлгүүдийн хамтын ажиллагаа хоорондоо ямар байх ёстой гэдэг тал дээр анхаарлаа хандуулах тал дээр Б.Болдбаатар дарга, шинэ удирдлагууд юу бодож байгаа юм бэ гэдгийг асуумаар байгаа юм.

Дараагийн нэг асуулт бол ер нь бол Улсын Их Хурал гэдэг бол өөрөө олон ургальч үзэл, ардчиллын чинь амин сүнс болсон байгууллага шүү дээ. Энэ дотор ямар ч үзэл бодолтой хэн ч ажиллаж болох газар. Мэдээж үе үеийн парламентын аль олонх болсон түүнээс хамаараад Тамгын газрын бүтцийн өөрчлөлт хийсэн нь нууц биш. Би энэ шинэ парламентын бүрэн эрхийн хугацаанд ялгаа байхгүй парламентын олонх хэн болсноос шалтгаалаад Тамгын газар бүтэц их өөрчлөгдсөн байх гэж бодож байгаа юм. Одоо тавьсан хүмүүс хэр зэрэг чадварлаг юм мэдэхгүй. Заримыг нь харахад баахан шинэ дарга нар байна л даа. Би заримыг нь барааг нь ч хараагүй, царай зүсийг нь хараагүй хүн олон л байх шиг байна. Манай хуучин хэд зарим нь байж л байх шиг байна. Энэ хүмүүс чинь яг парламент дахь ардчилал ямар нэгэн улс төрийн үзэл бодлоос үл хамааран эрх тэгш байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, цөөнх бие даасан гишүүд олонх яг адилхан хэмжээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бололцоогоор хангахад хэр зэрэг бэлтгэгдсэн хүмүүс юм бэ? Би бол парламентын түвшинд ажиллана гэдэг бол зүгээр нэг гудамжнаас шууд орж ирээд ажиллах газар биш гэж боддог юм. Ямар нэгэн байдлаар улс төрийн тогоонд чанагдсан байх хэрэгтэй, төрийн албаны тодорхой мэдлэг чадвар, туршлага хуримтлуулсан байх хэрэгтэй анхан, дунд шатанд төрийн захиргааны төв байгууллагад ч байдаг юм уу, тэгээд тэр хууль тогтоох үйл ажиллагаанд нэмэр хандив болохуйц юм гэсэн үүднээсээ ажилладаг байх болов уу гэж бодож байгаа юм.

Ер нь парламентын гал тогоонд ажиллах хүмүүс би бодохдоо зүгээр нэг сургууль төгсөөд ч юм уу, хальт гадаадад хэл сурчихсан хүн орж ирээд ажилладаг газар биш гэж боддог юм л даа. Энэ нэлээн улс төрийн болон төрийн захиргааны халуун тогоонд орж ажиллаад нэлээн юм үзчихсэн нас ахисан хүмүүс ажиллаж байх юм болов уу. Бид нар олон улсын парламентын туршлагатай танилцаж байсан, тэнд бол дандаа буурал үстэй тийм л хүмүүс ажилладаг юм байна лээ. Одоо энэ манай төрийн байгууллагуудын ажлыг хараад байх юм бол дандаа л нэг дөнгөж сургууль төгсөөд ирсэн юм уу, годгоносон охид залуучууд ажиллах юм байна шүү дээ. Энэ хэр зэрэг зөвлөж яаж ажилладаг юм би сайн мэдэхгүй байна. Тэгэхээр энэ байдал дээр хэр зэрэг зөв болсон юм бэ? Шинэ бүтцээ бий болгохдоо намын харьяалал гэж харгалзаагүй юм байгаа биз дээ? гэж асуумаар байгаа юм. Яагаад хүний асуултын хүч сулруулаад байгаа юм бэ? Мартуулчих юм. Би дараа нь тодруулъя.

А.Бакей: - Хариулъя.

Б.Болдбаатар: - Эхний асуултад хариулъя. Улсын Их Хурлын Тамгын газар Их Хурлын даргад үйлчилдэг юм уу, 76 гишүүн үйлчилдэг юм уу гэж асууж байна. Улсын Их Хурлын Тамгын газрын хуулиар олгогдсон үүрэг бол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэгтэй, энэ утгаараа бол Улсын Их Хурлын нийт 76 гишүүнд нь бүгдэд нь адилхан үйлчлэх ёстой. Ямар нэгэн байдлаар зөвхөн нэг даргад үйлчилдэг ийм бүтэц биш.

Улсын Их Хурлын дарга өөрт нь хажууд нь үйлчилж байдаг Даргын ажлын алба гэж тусдаа орон тоотой бүтэцтэй байгаа. Энэ бол тусдаа юм байгаа. Тийм учраас Тамгын газар 76 гишүүнд улс төрийн намын харьяаллаас үл хамаараад бүгдэд нь ажил жигд үйлчлэх ийм гэж ойлгож явж байгаа. Энэ чиглэлээр манай Тамгын газар үйл ажиллагаагаа явуулж байгаа. Мэргэжил арга зүйн зөвлөлөө туслалцааг аль зэрэг үзүүлж чадаж байгаа вэ гэж асуулаа. Ер нь бол бид нар Тамгын газрын шинэчилсэн бүтцийг хийхдээ бол ямар нэгэн байдлаар хүн сольж орон тоог өөрчилж халж солих зорилго агуулаагүй. Улсын Их Хурлын гишүүдээс намайг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилогдож байх үед өгч байсан үүрэг даалгаврын дагуу ер нь цаашдаа Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг таниулах зорилгоор Тамгын газрын бүтцийг өөрчлөх нь зүйтэй юм гэсэн ийм бодлого чиглэлээр хийгдсэн байж байгаа. Тэр хүрээндээ ч би түрүүн хэлсэн Байнгын хороодын ажлыг албыг сайжруулах, Байнгын хороодын үйл ажиллагааг чиглүүлэх энэ чиглэлээр явсан. Дээрээс нь дэлхийн сайн жишээ болдог парламентуудын туршлагыг судалж үүний хүрээнд бид нар бүтэц зохион байгуулалтаа ийм чиглэлээр явуулсан. Үүнийг явуулахынхаа өмнө бид нар өнгөрсөн оны сүүлээр бол ажлын байрны зураг авалт хийсэн, хэн ямар чиг үүрэг гүйцэтгэдэг юм, гүйцэтгэж байгаа үүрэг функц нь давхардаж байгаа юм уу, үгүй юм уу, энд хаягдсан юм байгаа юм уу гэдгийг нь бид нар нэлээн судалж шинжилж хоёр ч удаагийн ажлын хэсэг байгуулж ажиллаж чиг үүрэг баталж гаргаж хэлэлцүүлж баталсан байгаа. Тэгээд хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч явуулж байгаа. Гэхдээ зарим нэг ажилтны хувьд хариуцлага алдаад буруу дутуу хийсэн, харьцааны хувьд алдаж доголдсон юм байхыг үгүйсгэхгүй. Өнөөдрийн байдлаар бид нар удахгүй дараа 7 хоногоос бас шинэчилсэн ажилдаа дүн шинжилгээ хийх зорилго тавьсан байгаа. Ажлын байран дээр зураг авалт хийн хамгийн түрүүнд хэрэглэгч нар болж байгаа Улсын Их Хурлын гишүүдээсээ манай шинэчилсэн бүтцээр ажиллаж байгаа хүмүүс маань аль хир ажиллаж байгаа юм бэ гэдгээр санал агуулгыг нь авна. Мөн түүнчлэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан системчилсэн үнэлгээ хийх энэ чиглэлийн дагуу бол бүтэц зохион байгуулалтынхаа юм дээр анализ хийж, алдаа дутагдал гарсан байх юм бол засаж залруулах чиглэлийн юм хийхээр төлөвлөж байгаа.

Гишүүдийн зөвлөх, туслахад хэр үйлчилдэг вэ, бүлгийн ажлын албатай хэрхэн хамтарч ажилладаг вэ гэж асуулаа. Гишүүдийн зөвлөх, туслахууд дээр бид нар нэлээн их анхаарал тавьж байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн хууль тогтоох үйлчилгээнд хамгийн түрүүнд төлөөлж чадахуйц хэмжээний ажил бол Улсын Их Хурлын гишүүний туслах, зөвлөх, бие төлөөлөгч нар байдаг. Дээрээс нь нэмээд намын бүлгийн ажлын алба байдаг. Би өөрөө намын бүлэг дээр 3 парламент ажилласны хувьд үүнийг сайн ойлгож явдаг юм. Энэ гишүүдийн зөвлөх, туслахууд дээр тавигддаг шаардлагыг хүртэл тэгж хармаар байгаа ажиглагддаг юм. Өнөөдрийн байдлаар би статистик тоо гаргаагүй байна. Миний томилогдсоноос хойш гаргасан захирамжийн дийлэнх нь Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахуудыг томилох тухай асуудлын шийдвэр байдаг юм. Өндөр шаардлага тавьдаг байх, ирж байгаа хүмүүс нь шаардлага хангадаггүй юм шиг байгаа юм. Тэгээд халж, солих асуудал нэлээн хөдөлгөөнтэй байдаг. Хөдөлгөөн нэлээн өндөр байдаг учраас энэ дээр бид нар анхаарал тавьдаг. Олон жил гишүүдийн туслах,

зөвлөх хийсэн хүмүүс байдаг. Гэхдээ шинээр томилогдсон нь удахгүй халагдаад явчихдаг байгаа. Энэ дээр бид нар дүн шинжилгээ хийгээд гишүүдийн туслахуудад зориулсан 2 ч удаагийн сургалт зохион байгуулан явуулсан байж байгаа. Харамсалтай нь тэнд хамрагддаг хүний тоо тун цөөхөн. Ер нь гишүүдийн 50 орчим хувьд хүрэхгүй нь туслах, зөвлөхүүдээ явуулж сургалтад оруулдаг байж байгаа.

Бүлгийн ажлын албатай бид нар бүлэг маань өөрөө Улсын Их Хурлын төсөв тусдаа 5 төсөв байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн төсөв тусдаа байгаа гишүүд өөрсдөө зарцуулдаг байгаа. Байнгын хороодын төсөв тусдаа байгаа, намын бүлгүүдийн төсөв тусдаа байж байгаа. Улсын Их Хурлын Тамгын газрын төсөв, Улсын Их Хурлын нийтлэг арга хэмжээний төсөв гэсэн ийм 5 бүрэлдэхүүнээс бүрддэг. Бүлэг бол өөрөө төсвөө захиран зарцуулдаг болохоор өөрсдийнхөө үндсэн цалинг тогтоогоод нийгмийн асуудлаа шийдээд явдаг ийм боломжтой байгаа. Хамтарч ажиллах чиглэлээр хууль тогтоох, туслалцаа үзүүлэх чиглэлээр бид нар өөрсдийн бололцоотой хүрээнд хамтарч байгаа гэж ойлгож байгаа.

Тамгын газрын бүтэц бүрэлдэхүүнд шинэчлэгдсэн хүмүүс улс төрийн үзэл бодлоос хэрхэн ангид байж чадаж байгаа вэ гэж асууж байна. Ер нь бол Тамгын газарт шинээр томилогдсон ажилтнууд дотор улс төрийн томилгоогоор хийгдсэн гэж үзэхгүй байгаа. Бүгд Төрийн албаны тухай хуулийн дагуу томилгоо хийгдсэн байгаа. Зарим нэг ажилтнууд дээр дүгнэлтээр орж ирсэн, Төрийн албанд өмнө нь ажиллаж байсан туршлагатай хүмүүсийг авсан байгаа. Энэ хүмүүс ямар нэгэн байдлаар улс төрийн үзэл бодлоор гишүүдэд хандаж үйлчлэх учир шалтгаан байхгүй. Хэрвээ тийм байдаг бол энэ дээр бид нар шууд арга хэмжээ авна. Бид нар Тамгын газрын ажилтнуудын хувьд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, Тамгын газрын өөрийнх нь баримталдаг дүрэм энэ хүрээнд бид нар үйл ажиллагаа явуулж байгаа. Ямар нэгэн байдлаар хувь хүний хувьд тийм асуудал гарсан байхыг үгүйсгэхгүй, гэхдээ хэрвээ тийм юм гарсан байх юм бол бидэнд шуурхай бодитоор шаардлагатай арга хэмжээ авах ёстой гэж үзэж байна. Ер нь томилохоос гадна бид нар Тамгын газрынхаа ажилтнуудын мэдлэг боловсрол дээшлүүлэх, чадвартай хүмүүсийг ажиллуулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж байгаа. Үүний хүрээнд Гадаад харилцааны яам, Батлах хамгаалахын яам, Хууль зүй, дотоод хэргийн яамтай ажилтан шилжүүлэн ажиллуулах Төрийн албаны тухай хуулийн заалтыг баримталж ажиллуулж байгаа. Гадаад харилцааны хэлтэс дээр гэхэд манай 2 ч ажилтан маань гадаадад төлөөлж сууж байгаа Төлөөлөгчийн газарт хариуцлагатай ажил хийхээр томилогдоод явчихсан байж байна. Хууль зүй, дотоод хэргийн яаманд манай нэг ажилтан газрын даргаар ажиллаж байгаа, Гадаад харилцааны яаманд мөн газрын даргаар ажиллаж байгаа. Батлан хамгаалахын яамнаас Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр нэг хүн шилжүүлэн ажиллуулах журмаар ажиллуулж байгаа. Цаашдаа Сангийн яамтай, Эдийн засгийн хөгжлийн яамтай ярилцаад төсвийн шинжилгээний хэсэг дээр ажилтан шилжүүлэх чиглэлээр хүмүүс ажиллуулъя гэсэн санал тавиад байж байгаа, хариу өгөөгүй байна.

А.Бакей: - Тодруулах уу Су.Батболд гишүүн.

Су.Батболд: - Хоёр, гурван зүйл тодруулъя. Бид нар Байнгын хороодын

ажлын албыг бий болгосон л доо. Түүнээс хойш 6, 7 жил болж байна уу даа. АНУ-ын Бүгд найрамдахчуудын хүрээлэнгийнхний тусламжтайгаар ярьж байгаад Байнгын хороодыг ажлын албатай болгоё гээд нэлээн том албатай болгосон л доо. Үүний бүтэц нь хэр зэрэг зохимжтой байгаа юм бол гэж. Намайг Байнгын хороон дарга хийж байх үед цомхон байсан л даа. Тэгээд Тамгын газраасаа хуулийн зөвлөхийг аваад жишээ нь 7, 8 хүнтэй ажлын алба ажиллаж байгаа байх. Энэ бүтэц хэр зэрэг үр дүнтэй байгаа юм бол гэдгийг асуумаар байгаа юм.

Хоёр дахь нь ер нь энэ манай Тамгын газрын зүгээс гишүүдийн цалин хангамжтай холбоотой асуудлаар төсөв боловсруулаад Тамгын газраас Сангийн яам уруу явуулж байгаа байх тийм ээ? Тэгэхдээ та нар юу бодож байгаа юм бэ? Энэ хэдэн гишүүд чинь болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу? Болдог хүмүүс олон байдаг байх, яагаад гэвэл манай Их Хурлын гишүүд чинь бараг 70, 80 хувь нь бизнесменүүд, том компани, группын эзэд байдаг учраас болдог хүмүүс зөндөө байдаг байх. Түүнийхээ талаар дуугарахгүй ч үгүй юм ер нь бол бас энэ чинь энэ төрдөө зүтгээд ажил албаа хийгээд явдаг хүмүүс олон байна шүү дээ. Одоо өгч байгаа аль бараг 10-аад жилийн өмнө тогтоосон унаа утасны мөнгө гэдэг ч юм уу, цалин пүнлүү ерөөсөө хөндөгдөхгүй байгаа. Энэ асуудлаар судалгаа хийгээд болж байгаа, бүтэж байгаа юмыг нь, үүнтэй адилхан ялгаа байхгүй Тамгын газрын ажилтнууд, туслах, зөвлөхүүдийн цалин ялгаа байхгүй шүү дээ. Бид нар цалин пүнлүү өгөөд ажилд авъя гэх юм гайгүй боловсролтой болчихсон гадаадад төгсчихсэн хүн байх юм бол гээд, энэ чинь хамаг юмаа хураалгаад цалинг нь хүн томилуулья гээд өгөхөөр Тамгын газар хамгийн багаар нь тогтоогоод өгчих юм. Тэгээд гар дээрээ 400 мянган төгрөгийн цалин авдаг, тэгээд мастер хамгаалаад ирсэн хүн миний дэргэд ажиллах уу? Энэ дээр Тамгын газар ер нь бодлого гаргаж Сангийн яаманд ханддаг юм уу, гишүүд нь өөрсдөө нэг л их шударга сүрхий хүн болох гээд цалин мөнгөнийхөө талаар дуугардаггүй. Чимээ хумсаа нуусан муур шиг байдаг, үүний талаар хэн дуугарах ёстой юм бэ? Тамгын газар ер нь бид нар чинь Улсын Их Хурлын төсвийг батлахдаа Засгийн газраас дамжуулахгүй шууд Сангийн яамаар дамжуулахгүй өөрсдөө Төсвийн байнгын хороогоор хэлэлцдэг больё гээд ярьсан биз дээ. Энэ дээр нэг дуугарахгүй бол арай хэтэрч байна. Одоо ингээд юмны үнэ өсөөд байдаг, миний туслахаар ажиллаж байгаа хүн 400, 500 мянган төгрөгийн цалин аваад амьдарна гэдэг чинь автобусныхаа, хоолны мөнгөнд нь амьдрал нь хүрэхээ больчихож байгаа байхгүй юу. Үүнийг би ярих цаг нь болсон болов уу гэж бодож байна. Яагаад бид нар өөрсдийнхөө амьдралын төлөө ярьж болохгүй юм. Энэ дээр хэр зэрэг анхаарлаа хандуулж чаддаг юм бэ?

Дараагийн нэг асуудал нь Судалгаа алба гээд бид нар байгуулаад хуулиар Улсын Их Хурлын гишүүний орон тоог гаргаж өгсөн орон тооноо Улсын Их Хурлын 76 гишүүн бүгдээрээ нэг орон тоо хасаад Улсын судалгааны алба байгуулсан шүү дээ. Сая шинэ бүтцээр судалгааны албыг татан буулгаад судалгааны хэлтэс юм уу юу болгосон юм бэ? Уг нь бол Улсын Их Хурал шийдвэр гаргахад ялангуяа хуулийн төсөл боловсруулахад судалгаа их чухал байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол гэнэтхэн нэг цэцэн мэргэн хүн орж ирээд өмнө нь юу явж байсан нь бүү мэд би тийм хууль санаачилна гээд гүйж давхиж гарч ирээд л хууль санаачлаад явчихдаг, нөгөөдөх нь өмнөхтэй зөрчилдөх юм байдаг бас худлаа үнэн ч гэсэн судалгаа хийлгээд тэгээд хэдийгээр энэ судалгаа хийлгээд түүнийгээ үндэслэж байгаад улс орнуудад ийм

байдаг ийм зохицуулалт байдаг ингэж зохицуулбал зүгээр гээд. Өмнө нь юу гэдэг юм бэ, 1993 онд энэ хуулиар ингэж зохицуулж байгаад болохгүй болоод ингэж өөрчилсөн юм байна гээд үндэслэж байж хууль, шийдвэрийн төсөл боловсруулаад батлуулдаг бол зүгээр байгаа байхгүй юу. Гэтэл одоо судалгааныхаа төвийг татан буулгаад хэлтэс болгоод үйл ажиллагааны хувьд арай хумьсан юм болов уу гэж бодож байна. Үүнийг би буруу гэж бодож байна. 2011 онд намууд цуглаад парламентын засаглалаа төлөвшүүлж явъя гэдэг дээр санал нэгдчихсэн шүү дээ. Юу ерөнхийлөгчийг одоохондоо ярихгүй юм, парламентын ардчиллыг төлөвшүүлье гэсэн бол уг нь парламентын дэргэдэх судалгаа шинжилгээний ажил маш чухал байхгүй юу. Энэ дээр яагаад тийм шийдвэр гаргасан юм бэ? Энэ чинь хэр зэрэг явж байна вэ? Үүнийг цааш нь үргэлжлүүлэх бололцоо нөхцөл байна уу гэж асуумаар байна.

Б.Болдбаатар: - Байнгын хороодын ажлын албыг 2009 онд Тамгын газрын бүтэц зохион байгуулалтаар өөрчилсөн юм байна лээ. Тэгээд Байнгын хороодын ажлын албатай болсон. Тэр үеийн Байнгын хороодын ажлын алба бол яг Байнгын хорооны хуралдаан зохион байгуулах чиглэлээр л зохион байгуулалтад оролцдог байсан алба байдаг. Энэ дээр АНУ-ын Конгрессын туршлагыг судалж үзээд ер нь ганцхан хуралдаан зохион байгуулах биш, Байнгын хороодын хэлэлцэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын явж байгаа хууль, тогтоолын төсөл дээр байнга ажиллаж байдаг мэргэжлийн хүмүүстэй байх ёстой юм гэсэн энэ чиглэл рүү явсан. Өнөөдрийн байдлаар бол Байнгын хороон дээр хуралдаан зохион байгуулдаг тэр чиг үүргийг авчихсан. Харин Байнгын хорооны хэлэлцэж байгаа асуудлууд дээр нь ажилладаг мэргэжлийн ажилтнуудыг түрүүний хэлсэн зөвлөх, ахлах зөвлөх, референт, нарийн бичгийн дарга гэсэн ийм бүтэцтэйгээр ажиллагаа явуулж байгаа. Дунджаар нэг Байнгын хороон дээр 7-8 хүний бүрэлдэхүүнтэй, хамгийн олон хүнтэй Байнгын хороо бол Өргөдлийн байнгын хороо 10 хүнтэй байгаа. Яагаад гэхээр бүх гишүүдийн өргөдлийг дамжуулж авдаг болсон учраас ийм бүтцээр ажиллаж байгаа. Бүтэц маань 4 сараас хойш ажиллаж ирлээ. Нэг чуулганы хугацааг өнгөрөөчихлөө, одоо энэ чуулганы хугацаанд энэ бүтэц маань харин хэр болсон бэ гэдгийг та бүхнээс дараагийн 7 хоногт санал асууна. Үнэхээр болж байна уу, үгүй юу, хуучин нь зөв байсан юм уу, эсвэл шинэ болж байна уу болж байвал юуг нь засаж залруулах уу гэдэг талаар та бүхэн санал бодлоо хэлэх байх. Мэргэшсэн чиглэлээр Байнгын хороон дээр ажиллах нь зүйтэй юм гэсэн чиглэлээр тавьсан байгаа. Байнгын хороо болгон дээр хуулийн талын хүмүүс байх ёстой. Тэгээд Байнгын хорооныхоо мэргэжлийн чиглэлийн хүмүүсийг ажиллуулах гэсэн ийм чиглэлээр хуучин зохион байгуулалтаасаа салгаад хүмүүсээ нэгтгээд хийсэн байгаа.

Гишүүний төсөвтэй холбоотой асуудлыг бид нар өнгөрсөн 7 сард Төсвийн байнгын хороогоор 2014 оны Их Хурлын төсвийг хэлэлцүүлж байх үед яригдсан асуудал байгаа. 2008 онд батлагдсан Улсын Их Хурлын тогтоол байдаг. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүний төсвийг төлөвлөх, тайлагнах, зарцуулах гэсэн тогтоол байгаа. Энэ тогтоолоор Улсын Их Хурлын гишүүдийн хангамжийн асуудлыг шийдээд өгчихсөн байдаг юм. 2008 оноос хойш өнөөдөр 2013 он 5 жилийн хугацаанд мэдээж үнийн ханшийн өөрчлөлтөөс гадна ажлын шаардлага гэх мэтчилэнгээр зүйлүүд өөрчлөгдсөн байгаа. Энэ дээр бид нар ажлын хэсэг манайх дээр гаргасан ажиллаад эхэлж байгаа. Зөвхөн гишүүдийн төсөвтэй холбоотой

асуудлаар биш Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм журмуудыг нэг мөр болгож зөрчилтэй юмнуудыг нэгтгэж засах ийм ажлын хэсгийг бид нар өнгөрсөн 9 сард байгуулсан манайхан ажиллаж байна. Ний нуугүй хэлэхэд Их Хурал өөрөө төсөв дээрээ туйлын гар татаж ажилладаг шүү дээ, үүнийг өмнө нь би Их Хуралд ажиллаж байсны хувьд байнга ажиглаж явдаг юм. Их Хурлын төсөв яригдахаар төсвөө хамгийн түрүүнд хасчихдаг, тэгтэл Засгийн газрын байгууллагуудын төсөв харьцангуй хангамж хүрэлцээтэй байдаг. Бидэнд үнэхээр өнөөдөр байр савны хувь ч тэр хүндрэлтэй байгаа.

Ямар ч төрийн байгууллагад коридорт суугаад ажилладаг ийм төрийн байгууллага гэж байхгүй, стандарт ч байхгүй, өнөөдөр бид нар Төрийн ордны 3 давхрын коридорт манайхан боинг гээд нэрлэчихсэн байгаа шүү дээ. Нэг талд Тамгын газрын ажилтнууд нөгөө талд нь Улсын Их Хурлын гишүүдийн туслах, зөвлөхүүд сууж байдаг. Ерөнхийдөө Их Хурлын Тамгын газрын байр савны асуудал маш хүндрэлтэй байгаа. Намайг томилогдоод орж ирэхэд хамгийн түрүүнд баяр хүргээд байрны асуудал гишүүд ярьдаг. Гишүүдийн байрлаж байр ч өөр өөр талбайн хэмжээтэй байдаг. Зарим нь давхар өрөөтэй, зарим нь жижиг өрөөтэй, зарим нь нарнаасаа халдаг хэцүү ажиллахад тааруу ийм юмнууд байдаг. Тэгээд энэ хүрээнд бид нар бас Төрийн ордны шинэ барилгын асуудлыг хурдавчилж шийдэх шаардлага бол байгаа. Өнөөдрийн байдлаар Төрийн ордон дээр ард барина гээд шийдвэр гаргачихаад зарим нэг гишүүдийн тавьсан шаардлагын дагуу үйл ажиллагаа зогсчихсон байж байгаа. Шинээр газар тавих асуудал шийдэгдээгүй. Ибд нар Нийслэлийнхэнтэй уулзсан. Тэд нарт Төрийн ордны ногоон бүсийн талаар шинэ ордныг барих хүрээнд яаж шийдэж байгааг танилцуулсан. Хоёр хажуу талын зогсоолыг бол байгаа байдлаас нь өөрчлөөд газар доогуур зогсоолтой, дээрээ ногоон бүс мод ургамалтай байхаар төлөвлөөд явуулсан. Хуучин байгаагаасаа ногоон бүсийн хэмжээ нэмэгдэхээр ийм зураг гараад ирчихсэн байж байгаа. Одоо шинэчлээд зураг төсөл хийгээд явах юм бол ямар ч байсан эргэн тойронд байгаа ногоон орчны талбайн хэмжээ нэмэгдэхээр байгаа. Энэ Төрийн ордныг өнөө маргаашгүй шинэчлэхгүй бол Улсын Их Хурлын гишүүн ч тэр үйл ажиллагаа явуулж байгаа гишүүдийн зөвлөх, туслах, намын бүлгийн ажлын алба, Тамгын газруудын ажилтнуудын ажиллах бололцоо туйлын хүндрэлтэй байгаа гэдгийг та бүхэнд сонордуулья.

Цалин хангамжийн хувьд Улсын Их Хурлын гишүүдийн цалин хангамж, Тамгын газрынхан бүгдээрээ тогтоосон хэмжээгээрээ л явж байгаа л даа. Тэгээд энэ төрийн байгууллагуудын ажилчдын цалин төсөвтэй холбоотой, бүгд нь шийдэгдэх ёстой байх, ганцхан Их Хурлынхныг нэмээд байхаар бусад байгууллагынхан яах ёстой байгаа юм, тэрийг сайн хэлж мэдэхгүй байна. Нэмэх шаардлага бол байгаа, би түрүүн хэллээ манай дээр өндөр ур чадвартай хүмүүс ажиллах шаардлагатай байна. Өндөр ур чадвартай хуульчид, эдийн засагчид, санхүүчидтэй ажиллах шаардлага байдаг. Манай Тамгын газар дээр гадаад дотоодод яваад олон жил сургууль сураад туршлага хуримтлуулсан энэ чадварлаг хүмүүсийг хувийн компаниуд мөнгөөр зодоод авч байна шүү дээ. Миний мэдэхэд 2 газар ингээд авчихлаа. Зарим төрийн байгууллага ийм л байдалтай байгаад байгаа. Судалгааны албаны тухайд гэвэл судалгааны албыг татан буулгаагүй судалгаа, шинжилгээний хэлтэс гэж байгуулсан. Судалгаа, шинжилгээний хэлтэс

байгуулахдаа бид нар өмнө нь 2009 онд байгуулж байхад яг өнгөрсөн бүтэц хийж байхад багасчихсан байсан 23, 24 бүтэцтэй явуулж байсан. Энэ судалгаа, шинжилгээний хэлтсийг бид нар байгуулаад бүрэлдэхүүнд нь судалгааны албатай, архив, номын сантайгаар байгуулсан. Өнөөдөр судалгааны албанд бол 19 хүн ажиллаж байгаа, татан буулгаагүй хэвээрээ ажиллаж байгаа. Бид нарын хийж байгаа судалгаа маш ачаалалтай байгаа. Нэг хүнд ногдож байгаа судалгаа бол үнэхээр жижиг судалгааны 20 хэдэн хүнтэй алба байтугай бусад оронд 300, 400 хүнтэй тийм институт байдаг юм байна лээ. Ачаалал их байгаа учраас бид нар яг Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар богино хэмжээний мэдээлэл, лавлагаа гаргах ийм чиглэлээр ажиллая. Бодлогын судалгааг бол харин гадны судалгааны байгууллагаар гүйцэтгүүлж байя гэдэг ийм чиглэлээр үйл ажиллагаагаа төлөвлөөд 2013 онд 170 орчим сая төгрөг төсөвлөөд явж байгаа. Яг энэ чиглэлээр тусгай журам гарна, бид нар удахгүй эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын их, дээд сургуулиудтай хамтарч энэ чиглэлээр хамтарсан зөвлөгөөн явуулахаар бэлдэж байгаа. Ийм чиглэл байгаа.

А.Бакей: - Ж.Батзандан гишүүн асуулт асууя.

Ж.Батзандан: - Би товчхон асууя. Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг сонсож байгаа. Тэгэхээр 2013 онд ямар байсан 2012 онд ямар байсны тухай ярихаасаа илүүтэй 2014, 2015, 2016 ирэх он жилүүдэд ямар байх вэ гэдэг тухай ярих нь зүйтэй байх. Улсын Их Хурлын үндсэн ажил бол хууль батлах, баталсан хуулийнхаа хэрэгжилтэд хяналт тавих, төсөв батлах гээд үндсэн чиг үүрэг нь тодорхой байгаа. Өнөөдөр манай Улсын Их Хурлын Тамгын газарт олон сайн хуульчид байдаг болов уу гэж бодож байна. Харамсалтай нь өдрөөс өдөрт цөөрөөд чанартай хуульчдынх нь тоо багасаад байгаа, өөр байгууллага руу шилжээд байгаа ийм үзэгдэл ажиглагдаж байгаа. Олон яам руу, олон улсын байгууллага руу Улсын Их Хурлын дэргэд байсан туршлагатай хуульчид шилжсэн харагдсан. Ялангуяа захиргааны эрх зүйгээр олигтой хуульч олох гээд Улсын Их Хурлын Тамгын газар Хуулийн хэлтэс руу хандахад миний таньдаг байсан, хуучин ажиллаж байсан хуульчид нь бараг байхгүй болсон харагдана лээ. Тэгэхээр энэ боловсон хүчнийхээ асуудал дээр түлхүү сайн анхаараач. Америкийн Конгрессын дэргэд 300 чадварлаг хуульч ажиллаж байж Конгрессоос гарч байгаа хуулийн төслийг өндөр түвшинд чанартай гаргаж байгаа. Манайд бол Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газарт маш цөөхөн хуульчид байгаа, дадлага туршлагатай хуульчид тун цөөхөн болсон энэ чиглэлд анхаараач. Бид боловсон хүчнээ бэлтгэхээс гадна боловсон хүчнээ барьж үлддэг, хадгалж үлддэг боловсон хүчний бодлогоо урт хугацаанд төлөвлөж чаддаг энэ чиглэлд Тамгын газар явахгүй бол наад хуулийн бодлого чинь өөрөө хүндрэх нь гэдгийг Б.Болдбаатар даргад хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт, Засгийн газартай харьцах харьцаан дээр Улсын Их Хурлын Тамгын газрыг би анхаараач гэж. Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхтэй, санаачилсан хууль нь төсөвтэй холбоотой байвал Засгийн газраас санал авч байгаа, санал ирэх хугацаа нь 30 хоног гэдэг. Зарим хууль дээр Засгийн газар маш хурдан саналаа өгдөг нэг хоёрхон өдрийн дотор саналаа өгч байгаа. Зарим хууль дээр санал өгөхгүй 30 хоногийг нь тултал нь хүлээлгэж байгаа. Засгийн газраас

санал авах асуудал дээр, Засгийн газартай харьцах харьцаан дээрээ жаахан хурдтай, яаралтай, шийдэмгий хандмаар байна. Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын үйл ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгох чиглэлд хандмаар байна. Сүүлийн үед Улсын Их Хурал чинь Засгийн газрынхаа нэг хуулийн хэлтэс шиг, Улсын Их Хурлын Тамгын газар чинь нэг яамны хуулийн хэлтэс шиг болчихоод байгааг манай Тамгын газрынхан харж байгаа байх. Төрийн эрх барих дээд байгууллага юм бол төрийн эрх барих дээд байгууллага шиг л баймаар байна. Энэ дээр анхаарч гэж би та бүхэндээ хэлмээр байна. Тамгын газрын ажилтнуудын нөхцөл байдал амаргүй хүнд байгаа. Ажиллах нөхцөл хүнд байгаа, энэ ордон дотор агааржуулалтын систем шийдэгдээгүй ийм л байгаа. Эцэстээ энэ ордон дотор явж байгаа хуулийн хэлэлцүүлэг хэлэлцүүлэг биш хэрүүл болж дуусаж байгааг хэлэх хэрэгтэй. Тэгэхээр Тамгын газар энд байгаа ажилтнуудынхаа ажиллах нөхцөл байдал дээр түлхүү анхаараач. Тамгын газрын хуулийн хэлтсээс би нэг л зүйлийг хүсмээр байна. Монгол Улсад хэрэгжиж байгаа 500 гаруй хууль байгаа. Уг нь хөгжилтэй улс орнуудад 2500-3000 орчим хууль хэрэгждэг. Парламентаас баталсан 500 гаруй хуулийн чинь дийлэнх олонх нь хэрэгжихгүй байна. Хэрэгжилт нь цалгардаад байна, тэгэхээр манай Улсын Их Хурлын Тамгын газар судалгаагаар сайжруулаад ямар хуулиуд хэрэгжээд байна, ямар хуулийн хэрэгжилт нь цалгардаад байна, ямар хууль эрх зүйн давхар зохицуулалтууд бий болоод байна, давхар зохицуулалтаас болоод ажил явахгүй байгаа. Хууль хэрэгжүүлэх байгууллагууд аль хуулиа барьж ажиллахаа мэдэхгүй болчихоод байна. Ямар нийгмийн харилцаанууд эрх зүйн зохицуулалтгүй орхигдоод байна вэ? Энэ Байнгын хороодоос баталсан тогтоолын төслүүд, Засгийн газарт чиглэл өгсөн шийдвэрүүд яагаад хэрэгжихгүй байна, эсвэл хэрэгжиж байгаа бол хэдэн хувьтай хэрэгжиж байна гэсэн ийм тодорхой судалгаануудыг гаргаж ирэх ёстой. Бид хийсэн, баталсан хуулийнхаа хойноос хөөцөлддөг байх ёстой. Хуулийн хэрэгжилт дээр хяналт тавих ажлын хэсгүүд үр дүнтэй ажиллах ёстой, ингэж байж Улсын Их Хурал Улсын Их Хурал шиг төрийн эрх барих дээд байгууллага шиг болно. Энэ чиглэлдээ илүү анхаарч гэж хэлмээр байна.

Засгийн газартай харилцах харьцаан дээр, хууль батлах үйл явцдаа мэргэжлийн өндөр түвшинд баталсан хуулийнхаа хойноос тогтоол шийдвэрийнхээ хойноос өдөр болгон хөөцөлддөг болох ёстой. Энэ чиглэл рүү яваач гэж би та бүхэнд санал хэлж байгаа юм. Баярлалаа.

А.Бакей: - Хариулъя, ихэнх нь санал байлаа.

Б.Болдбаатар: - Манай шинэчилсэн бүтэц дээр Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих алба шинээр байгуулагдсан. Энэ Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих албаны хүрээнд бид нар Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоол, шийдвэрийн биелэлт ямар байгаа гэдэг дээр судалгаа хийгээд 2 ч удаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хэрэгжилтийн талаар өөрсдийнхөө саналыг хүргүүлсэн байж байгаа. Хийгдэх ёстой ажлууд хийгдэхгүй байгаа, орхигдсон талаар тайлбараа явуулсан. Дээрээс нь нэмэгдээд Улсын Их Хурлын гишүүдээс төрийн байгууллагууд, албан тушаалтнуудад хандсан албан бичгээр ханддаг, тэгээд цаг хугацаандаа хариу нь ирдэггүй алга болдог гэсэн ийм шүүмжлэл гардаг. Энэ дээр бид нар нэлээн судалгаа хийж үзсэн. Тэгээд өнгөрсөн 7 хоногийн эхээр бид нар энэ талаарх

судалгаагаа хүргүүлсэн байж байгаа. Ер нь ямар яамд, төрийн албан тушаалтан тэр албан бичиг очоод хариу өгөхгүй алга болчихдог, хэн нь өгдөг, өгсөн нь хариу нь шаардлагад нийцдэг үү гэдэг дээр манайхан судалгаа хийж үзсэн байгаа. Ийм талаар бид нар төрийн байгууллагуудтай харьцах харьцаагаа ажиллуулж байгаа. Тэр 30 хоногийн хувьд хуульд заасан 30 хоногоороо явж байгаа л даа. Хуулийн тухай хууль гэж шинэ хууль гарах гээд боловсруулагдаж байгаа. Энэ дээр анхаарах шаардлага байгаа байх. Бусдыг нь санал гэж ойлгож авлаа.

А.Бакей: - Ингээд асуулт хариулт дууслаа. Саналтай гишүүд санал хэлж болно. Д.Эрдэнэбат гишүүн, Л.Цог гишүүн, С.Баярцогт гишүүн, Сундуйн Батболд гишүүн, Миеэгомбын Энхболд гишүүн. Д.Эрдэнэбат гишүүн, Р.Бурмаа гишүүн хамгийн сүүлд.

Д.Эрдэнэбат: - Би энэ дээр.

А.Бакей: - Цагаа сайн бариарай, цагтаа.

Д.Эрдэнэбат: - Бас цагтаа юу. 5 минутад амжина, эхлэх үү?

А.Бакей: - 5 минут, цаг дээр тавьчихсан байгаа.

Д.Эрдэнэбат: - Би энэ тайланг хараад 2012 оны тайлан байх юм. Тэгээд 2013 оны сүүлээр хэлэлцэж байгаа. Энэ цаг хугацааныхаа хувьд ямар юм бол доо гэж. Цаашдаа үргэлжлэхдээ ингээд хэлэлцээд байх юм бол наадах 2012 оны юмыг санаж байгаа гишүүд тэр үед гишүүн байсан нь хэд юм, жишээлбэл би бол мэдэхгүй шүү дээ. Тэгээд Ц.Шаравдорж даргын үеийн юмыг Б.Болдбаатар дарга тавьдаг нь ч ямар учиртай юм бэ? Энэ бас Их Хурлын дэгийнхээ хуульд учир байх шиг байна. Тийм учраас энэ юмнуудаа өөрчлөөч, цагийн юмыг цагт нь хэлэлцэх ёстой. Тэгэхгүй энэ та нарын тайлан дотор чинь 2013 онд хийх ажлын тухай биччихсэн байдаг. 2013 он дуусаж байдаг, тэгээд иймэрхүү юмыг дахин дахин хэлэлцмээргүй байгаа юм. Тийм учраас Их Хурлынхаа хуульд өөрчлөлтүүдийг оруулаач гэдэг ийм санал байна.

Хоёрт, бүлэг, туслахууд, зөвлөхүүдтэй Тамгын газар нэг амьтай юм шиг ажиллах ёстой байгаа юм. Ялангуяа бүлгүүдийн үйл ажиллагаанд туслах, зөвлөгөө өгөх, хамтарч ажиллах, хуулийн асуудал дээр чиглэл чиглэлээрээ санал солилцох юм дээр туйлын дутагдалтай ажиллаад байх шиг надад санагдаад байгаа юм. Тийм учраас Тамгын газрынхан энэ дээр анхаарч ажиллаасай гэж бодож байгаа. Тамгын газрынханд хэлэх юм энэ Улсын Их Хурлын үйл ажиллагааны гол хандлага, чиглэл, бодлогын асуудал шийддэг цэг нь Байнгын хороо байгаа юм. Тэгэхээр энэ Байнгын хорооны өнөөдрийн манай явж байгаа байдал, дотоод зохион байгуулалт нь хууль гаргах хэмжээний түвшинд хүрч чадахгүй байх шиг надад анзаарагдаад байгаа юм. Байнгын хорооны хурал хамгийн халуун гал тогоо байдаг, хамгийн гол асуудлыг шийддэг мөртлөө зохион байгуулалт нь нэг л биш ажиглагдаад байгаа юм. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүдийн ирц нь хангалттай байх зайлшгүй шаардлагатай, төлөөлөл нь хангагдсан байх зайлшгүй шаардлагатай, асуудлыг хэлэлцээд санал өгсөн байх нь, хариуцах нь Их Хурлаас илүү хариуцлагатай үйлдэл баймаар байхад

энэ нэг л биш.

Тэгээд Байнгын хороон дээр орж ирээд ерөнхийдөө анзаарч байхад үнэхээр амин юмаа сайхан дотроо яримаар санагдахад орчин нь бас биш. Би юу гэж хэлэх гэж байгаа юм бэ гэхээр энэ дотоод зохион байгуулалтынхаа юмыг эргэж хараач, Байнгын хороо Их Хурлын гишүүдээс гарах тэр бүх бодол санаа нь чөлөөтэй гардаг, түүний төлөө хариуцлага хүлээдэг, тэр хуралд суусныхаа саналыг өөрөө өгч байж хариуцлага хүлээдэг энэ механизм уруу орон зохион байгуулалтын юмыг Их Хурал хийгээч. Энэ чинь хамгийн нэн тэргүүний ажил болчихсон юм биш үү гэж дотроо бодоод байгаа юм. Үнэндээ хэлэхэд бид нар Байнгын хороон дээр ямар асуудал ярьдаг вэ гэхээр хуулийн амин гол сүнснийг задалж ярьдаг ийм газар байхгүй юу. Тэгтэл хурлын байдалтай том зааланд суучихаад хэдэн бие рүүгээ хэрэлдээд зарим нь камер, телевиз, хэвлэлийнхэн орж ирэхээр наашаа харуулж бай би үг хэлье гээд циркийн манеж шиг болгочихоод байх юм. Тэгээд улс орныхоо дотоод асуудлыг амин чухал асуудлыг энгэр дэлгэсэн юм шиг ингээд энд тэндгүй цацаж яриад байх юм. Би үнэндээ хэлэхэд Байнгын хороон дээр орж ирээд буруу ч байсан, зөв ч байсан яг энэ үзэл бодлоо илэрхийлмээр санагдахаар улс төржилт нь ихсээд байх юм. Тэгэхээр энэ дээр манай Их Хурал онцгой анхаараач.

Би үүнтэй холбогдуулаад юу хэлэх гэж байгаа юм бэ гэхээр энэ 2014 оны төсөвт Байнгын хорооны үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах зүйлийг оруулж ирээч. Байнгын хорооны хуралдаан дээр яригдсан хэлсэн юм болгон видео бичлэгээр бичигддэг баймаар байна. Камерийн тоноглол хэрэгтэй баймаар байх юм. Ирцээ албан ёсоор хурууны хээгээр бүртгүүлээд Их Хурал дээр кноп дардаг шиг санал хураалтыг ингэж явуулмаар байх юм. Энэ чинь хууль төрж байгаа анхны хэлэлцүүлгийн орчин энэ шүү дээ. Тэгэхээр үүнийг алиа байдалтай болгомооргүй байхын төлөө Их Хурал зохион байгуулалтынхаа асуудал дээр анхаараасай гэсэн ийм бодол байгаагаа хэлчихье. Баярлалаа.

А.Бакей: - Л.Цог гишүүн.

Л.Цог: - Тэгэхээр парламентын ёсны дэлхийн хөгжлийн үзэх юм бол манай Их Хурал парламент маань 23 жилийг туулж явна л даа, харьцангуй залуу. Орчин үеийн түвшинг угтаж авах ийм сайхан боломжтой. Тамгын газаргүйгээр хууль тогтоох байгууллагыг төсөөлөх аргагүй шүү дээ. Ийм цалинтай, ийм хангамжтай, ийм нөхцөлтэй байхад бид нар хүнээс сайн ажил гэж шаардаж чадахгүй, сайн хүн барьж чадахгүй нь тодорхой. Өнөөдөр зүгээр нэг тайлан хэлэлцэх биш үүнийг Их Хурал өөрөө бодлого болгож тавих түвшинд ярих ёстой гэж бодож байна. Кувейт билүү аль газраас билүү 12 сая доллар өгөөд барь гээд 10-аад жил болж байна шүү дээ байшингаа барьж чадахгүй, үүнийг болиоч дээ гэж хэлмээр байгаа байхгүй юу. Бушуухан байшингаа барья, бид яагаад ч гишүүддээ хэлж байна шүү дээ хорооныхоо, Тамгын газарт хамаагүй л дээ. Бид үүнийг хөдөлгөж чадахгүй байна шүү дээ. Энэ нурж байгаа байшинг чинь яаж ч өөд нь татаад нэмэргүй болж байгаа байхгүй юу. Явахад сажигнаад дуугараад байгаа биз дээ. Энэ чинь эртний барилга шүү дээ, бүгд мэдэж байгаа. 50. 60 жил болж байгаа байшин шүү дээ. Тэгээд Засгийн газар, Их Хурал, Ерөнхийлөгчтэй гурвуулаа байж байгаа ийм газар хаана ч байхгүй шүү дээ. Муу юм бодоход ганц пар гэхэд бүгд явна шүү дээ. Газар хөдөлж

болно, хорлон сүйтгэх ажиллагаа явж болно, бөмбөг хаявал яах юм бэ гэсэн яриа миний үед гарч л байсан даа наян хэдэн оны үед. Үүнийгээ бид нар бодох ёстой шүү дээ. Ингэж асуудал босгохгүй, зүгээр нэг тайлан тавиад тийм ийм гээд яваад байвал ингэж яриад ч хэрэггүй шүү дээ.

Би Тамгын газрынхны цалинг нэмэх ёстой гэж боддог. Нөхцөл нь сайн барихгүй өөрийнхөө ажлын албыг ингэж байлгаж болохгүй шүү дээ. Би ийм хоёр юмыг сөхмөөр байгаа юм. Шинэ байшингаа босгоё, Тамгынхаа ажилтнуудын цалинг нэмье, орон сууцны хангамж нь юу байна. Энэ чинь эд нар тэсэхийн аргагүй зугтаагаад явна шүү дээ, хүн л болсон хойно амьдарна шүү, хаана цалин илүү амлаж байна тийшээ явна шүү дээ, буруу биш шүү дээ. Үнэнч сайн боловсон хүчингүй үлдэж байгаа юм гэдгийг бодох ёстой юм гэж бодож байна.

Дараагийн нэг хэлэх юм бол бага байж магадгүй, Их Хурлын гишүүд чинь байнга суугаа ажилтай, жаахан хөдөлж баймаар байгаа юм. Биеийн чилээ гаргаж, эрүүл мэндээ бодож энэ доороо очихоор подвальд юу байгааг мэдэж байна уу, та бүхэн харсан уу? Би ноднин очсон чинь үндсэндээ хэлэх аргагүй болоод гарсан л даа. Үүнийг өөд нь татах санаа явж байгаа нь сайн хэрэг гэж бодож байна. Олигтойхон мөнгө тавиад нүүр улайхгүй сайхан фитнесстэй болчихъё л доо бүгдээрээ. Ганцхан Их Хурлын гишүүн биш энд байгаа бүх ажилтнууд нь орж байвал Засгийн газрынхан нь орог, бүх явахад аймар бүдэрчихээр тийм газар бид нар байгаа юм байна лээ шүү дээ. Үүнийг өөд нь татах арга хэмжээ авч өгөөч Тамгын дарга минь гэж хэлмээр байна. Ер нь эцсийн утгаараа бол Тамгын газар үр дүн бүхэлдээ Тамгын газар насаараа байдаг алба байдаг юм байна шүү дээ. Ямар ч улс төрийн нам ялсан бай Тамгын газрыг оролддоггүй, Тамгын газрын дарга нь Их Хурлынхаа даргаас илүү цалинтай байдаг хангамж нь өөр байдаг. Тэгж байж ухаан нь төр тогтвортой байдаг ийм олон улсын жишгийг бид нар авахгүй өнөөдрийг хүрч байгаа юм бэ гэж бодмоор байгаа шүү. Анхаарах нь зүйтэй шүү гэж хэлмээр байна. Баярлалаа.

А.Бакей: - Сундуйн Батболд гишүүн. Ирцийн ирсэн дарааллыг харгалзаж байгаа шүү.

Су.Батболд: - С.Баярцогт өглөө унтахаа боль. Тамгын газрын үйл ажиллагаанд яах вэ дээ, би нэг их харьцаад Тамгын газрынхныг зовоогоод тэгээд байх, ингээд байх гээд байхгүй юм даа. Ер нь яах вэ сэтгэлд боломжийн гэж үзэж байна. Тамгын газар өнгөрсөн нэг жилийн хугацаанд хэдийгээр сонгуулийн жил байсан ч гэсэн харьцангуй гайгүй ажилласан болов уу гэж бодож байна. Над дээр хэлж яриад байх гомдол санал тэр нь тэгсэн энэ нь ингэсэн гээд байх юм алга. Зүгээр миний асуусан асуултууд бол та нар үйл ажиллагаандаа анхаараарай. Ер нь Улсын Их Хурлын Тамгын газар гэдэг бол Улсын Их Хурлын дарга, дэд дарга нар, Байнгын хороодын дарга нарт үйлчилдэг алба биш, монголын ард түмний төлөөлөл болсон 76 хүнийг үйл ажиллагаагаа явуулахад нь жигд боломжийн хэрээр хангадаг тийм байгууллага юм шүү гэдгийг байнга санаж яваарай гэсэн үүднээсээ би тиймэрхүү юм хэлсэн юм. Тийм учраас энэ дээр анхаарлаа хандуулаарай гэж бодож байна. Ер нь мэдээж Монгол Улс залуучуудын орон учраас залуу хүн ажиллах нь дээр байх. Гэхдээ би бас олон улсад түрүүн Ж.Батзандан гишүүн

хэлсэнтэй адилхан ажлаасаа чөлөөлөгдөөд энэ нь юу гэдэг юм бэ сонгуулийн үр дүнгээс хамаараад Тамгын газар бужигнаж байдаг тийм байгууллага биш байгаасаа гэж бодож байна. Энэ бол маш туршлагатай, бүх мэргэжлийн хүн ажилладаг ганцхан хуульч биш үүнд чинь бүх төрлийн салбарын хууль гардаг учраас бүх мэргэжлийн хүн ажилладаг. Тэр нь туршлагатай шүүгдэж гарч ирсэн. Би бол Засгийн газрын түвшинд яаманд ажиллаж байгаа хүмүүсээс илүү туршлагатай хүмүүс парламентын түвшинд ажилладаг байх ёстой гэж бодож байгаа юм. Яаманд ажиллаж байж тэнд туршлага хуримтлуулчихаад наашаа шилжиж ирдэг байх учиртай гэж би үзэж байгаа юм. Тэр утгаараа би түрүүн цалин хангамжийн асуудлыг ярьсан юм. Энэ дээр анхаарал болгоомжтой хандах ёстой юм.

Цаашдаа бид нар олон удаа ярьсан, түрүүн Д.Эрдэнэбат гишүүний ярьж байгааг бид нар хуулийн төсөл өргөн бариад маш нийгмийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгараад хойш нь татчихсан шүү дээ. Тамгын газрынхан хөөрхий мэдэхгүй л дээ, дэгийн хууль нь тэгээд гарчихсан юм чинь Байнгын хорооны хуралдаан нээлттэй явахаас өөр аргагүй. Өнөөдөр ч гэсэн хэрэв бид нар Тамгын газрынхаа үйл ажиллагааг өөрсдөө дотроо л ярих ёстой байхгүй юу. Хэрэв дотроо ярих юм бол энэ чинь зөндөө олон асуудал байна шүү дээ. Гэтэл бид нар бүх юманд нээлттэй дотроо янз бүрийн юм яриад тэр тэгсэн ингэж бичиг явах гэсэн тэгсэн байна лээ, миний гаднаас ирсэн бичиг тэнд тэгээд алга болчихсон байна лээ юм яриад сууж байлтай биш, ер нь бол ярих ёстой. Байнгын хорооны хуралдааны дэгийг бид нар нэлээн олон жилийн өмнө хоёр нам оролцож байгаад өөрчилье, бусад улсын парламентын дэг нь ийм юм байна, Байнгын хорооны хуралдаан гэдэг чинь шийдвэр гаргах процессын бараг 60, 70 хувь нь байдаг учраас энэ дээрээ бүгдээрээ жинхэнэ хуулиа ярьдаг байя. Зурагтын өмнө театрын жүжигчин шиг байхаа больё, ямар нэгэн гол дүр бүтээдэг байдлаа больё гээд үзээд бараагүй л дээ. Бид нар хааж байгаад л тусдаа аймар юм хийчих гээд байна гэсээр байгаад дэгийн хуулийг хүчингүй болгочихсон. Ер нь цаашдаа бол энэ дээр нэлээн анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хаана хэн нь юугаа ярьж байх нь бол. Тэгээд бөөн юм болсон тарчихаагүй. Тэгээд Байнгын хороод, бүлгийн ажлын алба, зөвлөх, туслахуудын үйл ажиллагааг нэлээн сайн нягтруулах хэрэгтэй. Энэ дээр манай ажлын албаны дарга нар нэлээн сайн анхаарлаа хандуулж ажиллах хэрэгтэй. Эд нар ингээд тусдаа юм шиг, өөр өөр юм шиг тийм байдалтай ажиллавал парламентын үйл ажиллагаа ерөөсөө явахгүй. Тэгэхээр энэ дээр нэлээн анхаарлаа хандуулж ажиллах ёстой юмаа гэсэн ийм санааг хэлмээр байна. Баярлалаа.

А.Бакей: - С.Баярцогт гишүүн.

С.Баярцогт: - Уламжлан болгон сонсдог тайлангаа сонсож байна. Би бас хэд хэдэн санал хэлье гэж бодож байна. Нэгдүгээрт нь бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулаад Төсвийн алба гэж байгуулж байгаа шүү дээ. Тэрийг анхнаас нь зөв байгуулмаар байна. Энэ чинь өөрөө бие даасан хууль батлагдаж гарна гээд байгаа, одоо манай төсвийн Засгийн газар дээр төсөв боловсруулаад өргөн барьж байгаа процесс өөрөө хоёр эзэнтэй болчихсон би бол чанарын хувьд муудаж байна гэж бодож байгаа. Тэгээд дээрээс нь Төсвийн алба өөрөө төсөв орж ирэхэд нь ажилладаг алба байх юм уу, эсвэл төсвийг боловсруулахаас нь эхлээд ажилладаг алба байх юм уу гээд ийм нарийн зохицуулалт хэрэгтэй байгаа юм. Яах

вэ, бид нарын анхны санаа нэлээн амбицтай Америкийн Конгрессын /Congressional Budget Office/ юм хийе гэсэн хүсэлтэй байсан. Тэгэхээр энэ дээрээ нэлээн анхаарч ажиллаарай. Яг түрүүн яриад байсан төрийн албаны сүлжээгээр цалинжуулаад ажиллуулах юм бол тэнд хүн ирж ажиллахгүй. Тэгэхээр парламентын Тамгын газрын энэ ажилтнуудын цалин хангамжийн асуудал дээр төрийн албаны сүлжээнээс гадуур гаргадаг ч юм уу, тийм санал боловсруулаад бид нар ярилцаад үзмээр байгаа юм. Яагаад гэвэл манайд байгаа хамгийн том дутагдал бол institutional memory-/байгууллагын санамж ой/ гэдэг юм уу даа, уламжлал хадгалагдах юм бол маш муутай. Тэгэхээр үүнийг хадгалж үлдээдэг системээ мэдээж хэрэг нэг талаасаа хүнээр дамжуулж байна, нөгөө талаараа институцээр дамжуулж хийнэ. Үүнийгээ баталгаажуулах тал дээрээ анхаараач гээд нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуудал бол би тэр судалгааны алба дээр барьж байгаа зарчмыг дэмжиж байна. Судалгааны алба бол суурь судалгаа хийж чадахгүй. Би бол ийм гашуун туршлага байгаа учраас хэлж байгаа юм. Судалгааны алба хийсэн судалгаагаа хэвлэчихдэг зузаан ном болгоод тэрийг нь хүмүүс ишлээд эхэлдэг, дараа нь судалгаа хийсэн хүн нь хариуцлага хүлээдэггүй байхгүй юу. Оюу толгойтой холбогдуулж хийсэн судалгаан дээр бол маш их хүн төөрөгдүүлсэн, тэгээд ганцхан хүн хийчихсэн тэгээд тэр нь хуульч хүн хийчихсэн ийм замбараагүй юм. Тэгээд би дараа нь хүлээхгүй гэж асуусан чинь би үүнийхээ төлөө хариуцлага хүлээхгүй гэж байгаа юм чинь. Тийм учраас яг лавлагаа хэмжээнд ажилла, суурь судалгаа байх юм бол эрдэм шинжилгээний байгууллагууд, зэрэг цолтой хүмүүс, дараа нь түүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг ийм хүмүүсээр хийлгэж явуулах нь зүйтэй шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Гуравдугаар санал бол цахим сүлжээтэй холбоотой асуудал байна. Төрийн ордон дотор хэд хэдэн сүлжээ ажиллаж байна. Аягүй үрэлгэн байна, тэгсэн хэрнээ Төрийн ордны зарим хэсэгт сүлжээ ажиллахгүй байна, барихгүй байна гэсэн үг. Тэгэхээр үүнийг ордон дотор гурав, дөрвөн ажиллаж байгаа байгууллага хоорондоо зохицоод хүчтэй сервер гэдэг юм уу, дамжуулах системүүд тавиад ашиглах тал дээр ярилцаач гэж хэлмээр байгаа юм. Яг цахим шуудангийн хувьд бол парламентын цахим шуудан бол фильтр аягүй муутай байгаа юм. Хамгийн их жанк орж ирдэг, өнөөдөр нээгээд ороход өглөө 10 мэйл ирчихсэн байгаа, түүний арвуулаа бараг жанк байгаа байхгүй юу. Ямар ч шаардлагагүй, тэгэхээр фильтр муутай. Тэгэхэд нээлттэй байгаа yahoo, Gmail-ийн фильтр хамаагүй сайн байна шүү дээ. Энэ дээр сайн ажиллаач. Ер нь бол цахим тал дээр нэлээн дэвшил гарсан ipad8 iphone үүгээрээ бид нар аягүй бахархалтай байгаа. Үнэхээр сайн ажиллаж байгаа, гэхдээ дотоодод байгаа сүлжээн дээр байгаа mail-ийн тэр сервер чинь муу байна. Энэ дээр анхаараач гэж хэлэх гэсэн юм.

Дараа нь энэ Гадаад харилцааныханд хандаж нэг зүйл хэлэхэд, энэ бичиг соёл дээрээ анхаармаар байна. Тэгэхгүй бол би парламент дээр хэлсэн Түркийг Турк гэж у, ү үсгээр бичээд, энэ бичгэн дотор Лаосыг а-ийн ард “о”-той бичээд л, “у”-тай бичээд ингээд байх юм. Ер нь бол зөв бичгийн дүрэм дээр маш их хэмжээний алдаа гардаг. Дээрээс нь нэр томьёо дээр ч гэсэн маш их өөрчлөгдөөд байдаг. Үүнийгээ нэг угаасаа компьютерын программ дээр чинь өгчихсөн байхад алдаанууд

нь гаргаад ирнэ шүү дээ. Энэ тал дээр бичгийн соёл дээр бас анхаараач гэж хэлмээр байгаа юм. Төрийн албанд энд ажиллаж байгаа хүмүүсийн баталгааны асуудал дээр тусад нь асуудал боловсруулж оруулж ирэх нь зөв. Тэртээ тэргүй Улсын Их Хурлын төсвийг шууд өргөн барьж байгаа шүү дээ. Улсын Их Хурлын төсөв чинь Сангийн ямаар хянагдахгүй байгаа шүү дээ. Бид нар өөрсдөө Төсвийн байнгын хороон дээр хэлэлцээд шууд өгчихөж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр нь мэдээж хэрэг тодорхой хязгаар дотор гэхдээ төрийн албан хаагчдынхаа цалин болон нийгмийн хангамжийн баталгааг нь сайжруулах хэмжээний зоригтой саналууд оруулж ирж байгаач. Тэгэх юм бол парламентын гишүүд дэмжээд явна гэдгийг хэлэх гэсэн юм баярлалаа.

А.Бакей: - Миеэгомбын Энхболд гишүүн.

М.Энхболд: - Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Би зүгээр нэг л асуудлаар санал хэлье гэж бодсон. Л.Цог дарга бас товчхон захыг нь дурдаад ярьчих шиг боллоо. Парламентын ордны барилгын талаар ер нь анхаарал тавих ёстой болов уу гэж бодож байгаа. Би 2010-2012 оны хооронд 2 жил гаруйн хугацаанд Шадар сайдаар ажиллаж байхдаа Засгийн газар талаасаа энэ парламентын ордны барилгыг барих ажлын хэсгийг нь ахалж ажиллаж байсан юм. Тэгээд тэр хугацаанд ордны барилгын 30 гаруй мянган метр квадрат талбайтай 14 давхар байшингийн зургийг хийгээд дуусгасан. Газрын геологи судалгаа хийгдсэн, монголын талын бүх мэргэжлийн байгууллагууд зурган дээр экспертиз хийсэн. Барилгын ажил эхлэхэд бэлэн болсон. Монголын 6, Кувейтын 6 компанийн хоёр талаасаа гараад 6 хуулийн этгээд байгуулагдаад тендерт материалуудаа өгөөд ганцхан Сангийн сайдын гарын зурагдаад л аль нэг компани нь шалгараад ажил эхлэх хэмжээнд очсон байсан. Мөнгө бол гарсан төсөв дээр тодорхой хэмжээний мөнгө дутагдаж байгаа. Кувейтын сангаас энэ дутагдаж байгаа хөрөнгө дээр бид бас анхаарал тавина гэсэн ийм бичиг ирүүлчих юм бол ажлыг нь эхлүүлж болно гэж хэлээд үндсэндээ жил гаруй боллоо. Энэ жил ажил их зогсонги байдалтай болж байна. Энэ дээр Тамгын газар бас анхаарал тавиаач, ер нь хүндрэл бэрхшээл гэдэг эдийн засгийн хүндрэлийг бид нар давж туулалгүй л яах вэ, гэхдээ зайлшгүй шаардлагатай юмандаа бол тодорхой хөрөнгө хүчийг яаж ийж зохицуулж байгаад Их Хурал шийдэж тавих ёстой. Одоо барилгын байршлын талаар олон байр суурь ингээд явдаг. Үүнийг Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэр гаргачихсан учраас тэр тогтсон байрлал дээрээ тогтоод хүн зүгээр бэлгэнд өгч байгаа мөнгийг ашиглаж чадахгүй хэдэн жил болж байгаа шүү дээ. Би бол төр ямар их хүнд сурталтай юм бэ гэдгийг жишээн дээр хэлье гэж бодож байна.

Парламентын ордныг барих ажил хэдэн жил болж байна вэ? Тусгаар тогтнолын ордныг барих ажлыг бас надад хариуцуулж байсан юм манай намын зүгээс. Тэгээд энэ барилга 2 жилийн дотор энэ барилга баригдсан. Тэгэхэд яг өнөөдөр энэ хоёр барилгыг хоёуланг нь тухайн үед хариуцаж байсан, нэг нь барилгынхаа шавыг ч тавьж эхлээгүй байх жишээтэй. Тийм учраас хүн юм өгье гээд байхад тэр зүйлийг нь аваад өөрсдөө гаргах дотоодын эх үүсвэрүүдээ тодорхой хэмжээнд төсөв дээрээ тавиад ирэх хавар энэ барилгын ажлыг эхлээч. Энд Их Хурлын гишүүд, Их Хурлын бүх Байнгын хороодын хурал тэгээд спорт биеийн тамир, соёл урлаг бүх зүйлийг нь бодоод тооцоод хийчихсэн ийм 14 давхар барилга

байгаа. Бидний өнөөдөр энэ ажиллах нөхцөл байдлын талаар сайн муу гэж ярьж байгаа асуудал бол энэ барилга баригдсанаар л шийдэгдэнэ. Түүнээс бид нар энэ байшингаа хэчнээн тодроод ч энэ байшин сунахгүй, тэлэхгүй учраас ямар ч боломж байхгүй. 210 машины зогсоолтой, ил машин зогсохгүй ийм байдлаар зураг төсвийн ажил юмнууд хийгдсэн. Үүнийг хариуцаж байгаа хүмүүс нь Засгийн газарт нэлээн шахалт үзүүлж ирэх жилээс барих талаас нь Б.Болдбаатар даргаа анхаарал тавиач. Би Их Хурлын гишүүний хувьд бүх талаас нь дэмжихэд бэлэн байна. Хүн яах вэ, байшин барилга барих гэлээ, хүнд суртал бий болгох гэлээ гэж ярих байх. Үнэн хэрэг дээрээ төр улс гэдэг чинь үеийн үед барилга байшинтай байж энэ эрх зүйт төрийг чинь бий болгож, хууль номыг чинь тогтоож, энэ улс орныг чинь удирдаж явах нь үнэн биз дээ. Би яах вэ өнөөдөр байж л байна. 10, 20 жилийн дараа энэ улсыг чинь бас монголын аавын хөвгүүд удирдаад явна. Тэр үед бололцоотой үед энэ барилгыг барьчихгүй яасан юм бэ гэж биднийг буруутгаж ойлгоно шүү дээ. Тэгэхээр энэ дээр улс төржилт байхгүйгээр аль аль талаасаа анхаарал тавьж энэ барилгын ажлыг ирэх жил эхлүүлэе, ийм саналыг хэлэх гэсэн юм.

А.Бакей: - Баярлалаа. Р.Бурмаа гишүүн.

Р.Бурмаа: - Хоёр зүйл хэлье. Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох чиглэлээр нэлээн зүйлүүд хийгдэж байгаа. Тэгээд энэ дээр нэмээд бас дадлага хийдэг туршлагыг нэвтрүүлэх талаар санаачилга гаргаж ажиллаач. Энэ тал дээр Б.Болдбаатар даргатай ярьж байгаа. Өргөдлийн байнгын хороон дээр Их Сургуулийн оюутнуудыг ирж дадлага хийлгэх чиглэлээр ажиллуулъя гэж ярьж байгаа. Тэгэхээр бүх Байнгын хороо, Улсын Их Хурлын судалгааны төв дээр ч гэсэн оюутнуудыг дадлага хийлгэх, мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд ч гэсэн тодорхой хугацаагаар ирж дадлага хийдэг танилцдаг боломжуудыг хангах ажлыг бас санаачлан хийгээч гэсэн саналыг хэлж байна. Их Хурлын Тамгын газрын ажилтнуудад ажил дүгнэх шалгуур их тодорхой баймаар байна. Зарим сайн чадвартай хүмүүст нь ажлын ачаалал нь их байгаад байдаг, зарим нь нэг хүмүүсийг нь харахаар Байнгын хороонд гар өргөсөн тоо тоолохоос өөр ажил хийдэг юм уу, үгүй юм уу гэж харагдахаар үгүй бол хүрч ирж хуралдаа ирээч гэсэн ирц шаардахаас өөр ажил хийж байгаа үгүй нь мэдэгдэхгүй тийм байдал бүлгийн ажлын албанд ч Байнгын хорооны ажлын алба дээр ч бас харагдаад байх юм. Тэгэхээр ажил үүргийн хуваарь ажлыг нь дүгнэх шалгууруудыг их тодорхой болгож өгвөл тэр дээр бүх хүмүүсийн ажлыг дүгнэхдээ Тамгын газрын дарга өөрөө биечлэн тэр болгон орж амжихгүй байх л даа. Байнгын хорооны дарга нар, гишүүд яаж тэр ажилтнуудын ажлыг дүгнэхэд оролцох юм бэ, сайн ажиллаж байгааг нь цалингаас гадна урамшуулах ямар механизмууд байх юм бэ, жилийн эцэст тодорхой нэмэгдэл цалингаар урамшуулахаас эхлээд бусад ямар хэлбэрүүд байж болох юм бэ, ажлын шаардлага хангахгүй байгаа бол ямар байдалтай хандах юм бэ гэдэг ийм зүйлүүд баймаар байна. Сая бол гишүүд нийтлэг хангамжийг сайжруулъя гэсэн. Энэ дээр би санал нэгтэй байгаа. Гэхдээ энэ дотор ялгавартай баймаар байна. Сайн ажиллаж чадаж байгаа чадавхтай, ачаалал өндөртэй байгаа хүмүүсийг улам урамшуулж, тогтвор суурьшилтай ажиллах, урам зоригийг нь нэмэх чиглэл дээр тодорхой баймаар байна. Чадахгүй байгаа хүмүүсийг нь бас шаардлага хангахгүй байгаа бол явуулж баймаар байна. Энэ чиглэлээр гишүүдийн оролцоонд яаж ажил

дүгнэхэд оролцох уу гэдэг нь тодорхой баймаар байна. Энэ дээр сургалтуудыг нэмээч гэж хэлмээр байна. Их Хурал шинээр бүрэлдсэний дараа Их Хурлын гишүүдийн туслахууд, зөвлөхүүд нэлээн шинэчлэгдэж байна. Бүлгийн ажлын алба ч гэсэн нэлээн шинэ хүмүүс байна. Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих гээд ард түмний төлөөлөл гээд энэ үйл ажиллагаанууд ч бас тодорхой дүрэм журамтай. Тэгээд үүний чиглэлээрх ажлыг сургах сургалтуудыг ээлж дараатай хийж энд туслах зөвлөхүүдийг ажлын аппаратуудыг бас оролцуулж баймаар байна. Энэ чиглэлээр хэр зэрэг төсөв батлагдаж байгаа бол сайн мэдэхгүй байна.

Тонг төхөөрөмж, техник хэрэгслээр гайгүй хангагдаж байгаа. Тархи толгойнд нь мэдлэг олгох чиглэлийн ажлыг бас нэмж хийх шаардлага байна гэж харж байна. Нээлттэй хэлэлцүүлгийн өрөө тасалгааг тохижуулахаар болж байгаа гэж би ойлгож байгаа. Ирэх жилийн төсөвт орсон байх тийм ээ?

А.Бакей: - Хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд асуулт асууж саналаа хэллээ. Р.Гончигдорж гишүүн товчхон.

Г.Гончигдорж: - Түрүүн хөндөгдөөд байгаа ордны тухай асуудал л даа. Тодорхой хэмжээгээр хариуцах үүргээр ажиллаж байгаа юм. Нөхцөл байдлыг харах юм бол парламентын ордны асуудлыг парламент өөрөө хариуцах биш парламент Засгийн газартай цаг хугацаатай чиг үүрэг бүхий үүрэг даалгавар өгч Засгийн газар үүнийг эрхэлж барих, бариулах ажлыг Байнгын хорооноос гарсан тогтоолын дагуу товлосон газар дээр мөн тогтсон зураглалын дагуу түрүүн М.Энхболд дарга хэллээ. Засгийн газар шуурхай үүрэг өгч дотоодын эх үүсвэр болон гадны эх үүсвэрүүдийг нэмж дайчлах энэ чиглэлээр Улсын Их Хурал ажиллах шаардлагатай гэж ойлгож байгаа юм. Түүнээс парламент өөрөө энэ барилгыг бариулна гэдэг бол зөв зүйл биш харагдаж байгаа юм. Гарах ёстой шийдвэрүүдийг нь гаргаж өгнө гадна дотно эх үүсвэрийнх нь талаар нэгэнт байрлах зураглал бусад юмыг нь хийчихсэн. Цэцэрлэгийн асуудал дээр нэлээн янз янзын юмнууд ярьдаг. Асуудлыг нь үнэндээ судлаад үзэх юм бол харин ч цэцэрлэгийн ногоон орчны байдал нь бол сайжирч, энэ орчны байгаль орчны нөхцөл байдлууд харин илүү сайжрах ийм нөхцөлөөр байгаа юм байна лээ. Бид нар заримдаа ичингүйрсэн байдалтайгаар өөрсдийнхөө байр савны тухай яриад байна гэдэг тэр байдал болоод тэгээд дараагаар энэ парламент ордноо барих гэж хотын төвийн түүхэн ногоон байгууламжийг устгах гэж байна, арилгах гэж байна гэсэн ийм зүйлүүд. Ногоон байгууламжийн хувьд хойд цэцэрлэгийн хувьд мэргэжлийн судлаачид судлаад энэ хойд талын цэцэрлэг бол эргэж сэргэх тийм байгаль орчны өөрийн боломж байхгүй болчихсон ийм гэдэг дүгнэлтүүд гарчихсан байж байгаа шүү дээ. Тийм учраас энэ дээр Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаагийнх Улсын Их Хурлаар энэ түвшинд шийдвэр гаргах шаардлагатай бол Засгийн газарт энэ ордныг бариулах асуудлыг түрүүн М.Энхболд дарга хэллээ ирэх жилээс эхлүүлэх, энэ ажлыг зохион байгуулах, гүйцэтгэгч компаниудыг нь шалгаруулахаар явсан тэр шатны ажлыг цааш нь үргэлжлүүлээд явах ийм чиглэлийг гаргах.

Гадаад харилцааны яамтай бол Кувейттэй цаашид энэ байрыг гүйцээж барихад шаардлага байгаа гадна талын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийн тухай яриа хэлцлийг ч гэсэн хийх шаардлагатай юм гэж ингэж үзэж байгаа юм.

Парламент өөрөө гадна талдаа тийм мөнгө хөрөнгөний гэрээ хэлцлүүд хийгээд байх ёстой биш шүү дээ. Бид нар эрх мэдлийн хуваарилалт чиг үүргүүдийн тал дээрээ бол парламент өөрөө жишиг болохгүй бол бид нар газар болгон өөрийнхөө мэдлээр үйл ажиллагаа явуулаад байдаг биш, нэгдсэн газар үйл ажиллагаагаа эхэлдэг, хяналт тавьдаг газар нь хяналтаа тавьдаг шийдвэр гаргадаг газар нь шийдвэрээ гаргадаг байх тэр зарчмаа бид нар энэ төрийн ордон дээрээ хүртэл хэрэгжүүлэх шаардлагатай гэж ингэж боддог юм. Үүнийг хэлье гэсэн санасан юм.

А.Бакей: - Баярлалаа, ингээд Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны эцсийн чанар үр дүн бол Улсын Их Хурлын Тамгын газар түүний бүрэлдэхүүний чанар ажлаас шалтгаална. Өнөөдрийн энэ хуралдаанаар тайланг авч хэлэлцэхдээ Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс маш сайхан үнэтэй саналууд гарлаа. Тийм учраас Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс гаргасан саналыг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлж ажиллах шаардлагатай гэдгийг хэлье.

Улсын Их Хурлын Тамгын газарт Байнгын хорооны хуралдаанаас тэмдэглэлээр тодорхой үүрэг даалгавар өгөхөөр шийдвэрийн төсөл бэлдсэн байгаа. Та бүхэнд тараасан 8 чиглэлийн даалгавар байгаа. Үүнийг заримыг нь та бүхний саналд тулгуурлаад найруулж өөрчлөхөөр болж байгаа. Жишээлбэл 7 дугаар үүргийг бол Улсын Их Хурлын Тамгын газрын нэгжүүд Улсын Хурал дахь намын бүлгүүд, Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахуудтай үйл ажиллагаагаа уялдуулж хамтарч ажиллах энэ асуудлыг тодорхой болгох. Мөн 8 дугаар асуудлын хувьд бол Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын ажлыг дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох тогтолцоог тодорхой болгож, тэдний мэргэжил ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх арга хэмжээ, сургалтыг тогтмол зохион байгуулах гэсэн ийм найруулгын шинжтэй байхаар байна. Нэмж гишүүдийн гарсан саналд тулгуурлаад ийм саналуудыг үүрэг даалгавар өгөх асуудалд тусгая гэж бодож байгаа. Улсын Их Хурлын Тамгын газрыг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн чадварлаг боловсон хүчнээр хангах, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл бололцоогоор хангах талаар тодорхой санал боловсруулж шийдвэрлүүлэх гэж. Энэ дотор нөгөө төрийн албаны сүлжээтэй байх уу, үгүй юу гэдэг асуудал яригдлаа шүү дээ. Тийм учраас энэ дээр тодорхой санал боловсруулж холбогдох албан байгууллагаар шийдвэрлүүлээч гэж.

Дараагийн асуудал бол Улсын Их Хурлын Байнгын хорооны үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд тодорхой өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэхээр энэ саналыг нэмж тусгая гэж байгаа. Р.Гончигдорж болоод Миеэгомбын Энхболд гишүүн нарын бусад гишүүдийн саналд тулгуурлаад тэмдэглэлээр Засгийн газарт нэг үүрэг даалгавар өгөх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ бол Улсын Их Хурлын шинэ байрыг барихаар өмнө нь товлож шийдвэрлэсэн газарт нь 2014 оны хаварт багтааж барих ажлыг эхлүүлэх асуудлыг Засгийн газарт үүрэг болгох, мөн санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох байгууллагуудтай ярьж шийдэх талаар санаачилгатай ажиллах асуудлыг Гадаад харилцааны яаманд үүрэг болгох нь зүйтэй гэсэн ийм утгаар та бүхний саналыг тэмдэглэлээр өгөх даалгаврын төсөлд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Су.Батболд: - Тамгын газарт бид нар чиглэл өгөх гээд байгаа шүү дээ. Би бол энэ парламентын ордны төлөө түрүүн цаг аваад яах вэ гээд ярьсангүй. Хэдэн арван жилийн яриа шүү дээ. Үүнийг Б.Болдбаатар дарга ч юм уу Тамгынхан мэдэхгүй шүү дээ, хөөрхий амьтан. Энэ тэмдэглэл дотор оруулж болохгүй тусдаа гаргаж явуулахгүй бол.

А.Бакей: - Тусдаа.

Су.Батболд: - Тэгэхгүй бол наадах чинь улс төрөөс болоод байгаа байхгүй юу. Өдийд бид нар бариад ороод үүнийгээ янзлах цаг болчихсон байхад чинь.

С.Баярцогт: - Байртай холбоотой асуудал чинь сая шинэ парламент байгуулагдаад би тэр ажлын хэсгийг нь ахлаад надад ямар үүрэг өгсөн бэ гэхээр ордон барих байрыг нь тодорхойл гэсэн юм. Түрүүн М.Энхболд дарга хэлсэн, хүчин төгөлдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолтой байхгүй юу энэ ордны хойд талд барь гэсэн. Тэгсэн чинь гишүүд өөрсдөө улс төржөөд хойно очиж мод тариад хойд зүлгийг яах юм бол болохгүй гээд гарын үсэг цуглуулаад хамгийн сүүлд эмэгтэй гишүүд бүгд гарын үсэг зураад өгчихсөн. Тэгээд зогсчихсон шүү дээ, одоо асуудлын гол нь үндсэндээ Засгийн газар ч биш, Тамгын газар ч биш. Энэ зүгээр гишүүд өөрсдөө улс төр хийдэг байхгүй юу. Шийдвэр нь хүчин төгөлдөр байхгүй юу.

А.Бакей: - Энэ дээр Байнгын хорооноос шийдвэр гарсан тэр шийдвэр бол хүчин төгөлдөр байгаа шүү дээ. Тэгээд С.Баярцогт гишүүн Их Хурлын дэд дарга байхдаа ажлын хэсэгт ажиллаад бас өөр хувилбар янз бүрээр үзээд үндсэндээ зогссон. Дараа нь дахиад шинэчлэгдээд Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд бол саяын эсэргүүцэж байгаа гишүүдийг бүрэлдэхүүнд нь оруулсан байгаа. Ерөнхийдөө ойлголцолд хүрэх чиглэл рүүгээ явж байгаа гэж ойлгож байгаа. Ганцхан энэ ажлыг зохион байгуулахыг нь Засгийн газарт үүрэг өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа шүү дээ. Ерөнхийдөө энэ чиглэлээрээ үр даалгавар өгнө. Ингээд саяын үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газарт үүрэг болгож байна. Ингээд нэгдүгээр асуудлыг хэлэлцэж дууслаа.

Хоёр дахь асуудал бол Улсын Их Хурлын Тамгын газрынханд бол баярлалаа.

Хоёр. Зарим аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцсан дүн.

Ажлын хэсгийн гишүүн Р.Бурмаа танилцуулна.

Р.Бурмаа: - Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, Улсын Их Хурлын гишүүн, Нутгийн удирдлагын дэд хорооны дарга Д.Батцогт, Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Р.Бурмаа, Байнгын хорооны зөвлөх, референтын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2013 оны 4,8,9 дүгээр сард Төв, Хэнтий, Ховд аймаг, Нийслэлийн Баянгол, Сүхбаатар, Хан -Уул дүүргүүдийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Улсын Их Хурлын үйл

ажиллагааг сурталчлах төвийн ажилтай танилцлаа.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, хууль сурталчлах, иргэдийн оролцоог хангах чиглэлээр хийгдэж байгаа ажилтай удирдамжийн дагуу танилцаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, баг, хорооны Засаг дарга, Иргэдийн нийтийн Хурлын дарга, тэргүүлэгч нийт 300 гаруй хүнтэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсож, тавьсан асуултуудад Улсын Их Хурлын гишүүд зохих хариултуудыг өгсөн болно.

Дээрх аймаг, дүүргүүд хуулийн дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаануудаа 5-13 удаа, тэргүүлэгчдийн хурлыг 20 гаруй удаа хуралдуулж, зохион байгуулалтын асуудлаа хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Засаг даргын мөрийн хөтөлбөр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны Үндсэн чиглэл, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөө батлан ажиллаж байгаагийн дээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодоо байгуулан ажиллуулж эхэлжээ.

Аймаг, дүүрэг, хороодод Иргэний танхим байгуулж, хууль тогтоомжийг сурталчлах, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэдэд шаардлагатай мэдээллийг өгөх хэлбэрээр ажиллаж байна. Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь “Иргэний танхим”-аа Засаг даргын Тамгын газраас тусад нь шинээр байгуулж, иргэдэд үйлчилж байгаа нь бусад газруудад туршлага болохоор сайн ажил болсныг зориуд тэмдэглэж байна.

Тус Байнгын хорооны гишүүд дээрх аймаг, дүүргүүдийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр байгуулагдсан бүтээн байгуулалтын ажилтай газар дээр танилцсан бөгөөд иргэдийн саналын үндсэн дээр хийгдэж байгаа ажлууд нь үр дүнтэй, иргэдийн сэтгэлд хүрсэн сайн арга хэмжээ болсон байлаа.

Аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шинээр сонгогдсон төлөөлөгчид, баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын тэргүүлэгчдийг сургах, гарын авлагаар хангах ажлыг 1-3 удаа зохион байгуулсан байв.

Монгол Улсын Их Хурлын тухай, Засгийн газрын тухай, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагуудын үйл ажиллагаа ил тод байх, тэдгээрээс гаргасан зарлиг, хууль, тогтоол, бусад шийдвэрүүдийг олон нийтэд мэдээлж байх зорилготой Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас байгуулсан “Иргэний танхим”, Улсын Их Хурлын Тамгын газраас байгуулсан “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төв”, Засгийн газраас байгуулсан “Эрх зүйн туслалцаа үзүүлэх төв” гэж ажиллаж байна.

Эдгээр танхим, төв нь хууль, тогтоомжийг сурталчлах, хуулийн төсөлд санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд түгээх ажлыг зохион байгуулж байгаа зорилго, чиглэл нь адил, үндсэндээ ижил төстэй боловч иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын дэргэд тус тусдаа ажилладаг бөгөөд эрх зүйн байдал нь тодорхой бус, ажлын давхардал ихтэй, уялдаа муутай, үргүй зардал ихтэй, нэгдсэн

зохицуулалт хангалтгүй байгаа нь ажиглагдлаа. Иймээс дээрх танхим, төвүүдийн үйл ажиллагааг нэгтгэн, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль, тогтоол, бусад шийдвэрүүд, түүнчлэн аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтээр дагаж мөрдөх шийдвэрүүдийг олон нийтэд шуурхай мэдээлэх, сурталчлах үүрэг бүхий “Иргэний танхим” болгон өргөтгөн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулан ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоо, төсөв харилцан адилгүй байгааг анхаарах, ялангуяа сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг ажлын албатай болгох асуудлыг судлан үзэх хэрэгтэй юм.

Уулзалт, ярилцлагын үед Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Сонгуулийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах талаар нийт 40 гаруй хүнээс 105 санал гаргасан бөгөөд тэдгээрийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулж байна.

Цаашид нутгийн удирдлагын эрх мэдлийг нэмэгдүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг төсвийн хуваарилалтыг оновчтой болгох, баг, хорооны удирдлагыг чадавхжуулах шаардлагатай байна.

Цаашид анхаарах асуудлууд:

-Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, төсөв харилцан адилгүй, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй байгааг анхааралдаа авч, жишиг тогтоох эсэх асуудлыг судлан шийдвэрлэх;

-Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог хангах ажлыг удирдан зохион байгуулахад баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын үүрэг нэмэгдэж байгааг харгалзан иргэдийн нийтийн Хурлын даргад тодорхой шалгуур тавих, түүнд нийцсэн цалин хангамжтай болгох асуудлыг судлан шийдвэрлэх;

-иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний Тамгын газрын ажлын уялдаа холбоог сайжруулж, аливаа асуудалд нэгдсэн зорилго, чиглэлтэй хандан ажиллах;

-Хууль, тогтоомжийг сурталчлах, иргэдийн оролцоог хангах, байгууллага бүрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад анхаарах;

-иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, баг, хорооны сонгуультнуудыг сургалтад хамруулж ажиллах шаардлагатай гэж үзлээ. Ажлын

хэсгийн хэсгийн ахлагч А.Бакей, Д.Батцогт, Р.Бурмаа гишүүн. Ийм илтгэл хуудсыг танилцуулж байна.

А.Бакей: - Р.Бурмаа гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг нэлээд урт хугацаанд ажилласан юм. Тэгээд дүнг нь өнөөдөр танилцуулж байна. Эрхэм гишүүдэд энэ асуудлаар Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Засгийн газарт чиглэл өгөх тухай, ингээд энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Асуулттай гишүүд байхгүй бол асуултаа таслах уу? Асуулт байхгүй юм байна тийм ээ? Сундуйн Батболд гишүүн.

Су.Батболд: - Энэ манайхан чинь Хэнтий, Төв аймаг явсан уу?

Р.Бурмаа: - Гишүүд тогтоолын төсөл авсан юм уу?

А.Бакей: - Төв, Ховд.

Су.Батболд: - Ховд бас явсан юм уу? Энэ манай Байнгын хорооны гишүүдийг орон нутагт ажиллаж байхад Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн талаар иргэд ямархуу бодолтой байх юм бэ? Мөн Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар ямар үзэл бодлоо илэрхийлж байх юм бэ? гэдгийг тодруулж Байнгын хорооноос асуумаар байгаа юм. Энэ дээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцсан юм чинь Үндсэн хууль, Засаг захиргааны хуульд ч иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, эрх мэдэл, цаашдын хандлагын талаар ямар үзэл бодол илэрхийлж байх юм бэ? гэдгийг сонсмоор байх юм.

А.Бакей: - Р.Бурмаа гишүүн эхлээд хариулах уу? Би хариулчихъя тэгвэл. Тэгэхээр энэ дүүргүүдээс гурав, аймаг бас гурав явсан л даа. Энэ нам намын төлөөлөл байсан ажлын хэсэгт. Гэхдээ тухайн үедээ зав нь гараагүй явж чадаагүй. Тэгээд энэ дээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаар, төрийн албаны талаар, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар, Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах талаар гээд, Улс төрийн намын хуульд өөрчлөлт оруулах талаар баахан санал гарсан. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулсан. Энэ саналуудыг бид нэг бүрчлэн судлаад тайлбарынхаа хамт нэгтгэсэн байгаа. Үүнийг бид байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байгаа шүү дээ. Үндсэн хуулиар, сонгуулиар, улс төрийн намаар. Тэр ажлын хэсэгт хүргүүлэхээр ингээд бэлдэж байгаа. Ерөнхийдөө хандлага нь бол Үндсэн хуульд өөрчлөлт оруулах цаг нь болсон. Ялангуяа 2000 оны өөрчлөлтийг иргэд эргэж засаж сайжруулах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа нь олон газар давтаж байна лээ. Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хувьд бол бас олон жилийн турш үндсэндээ орон нутаг дахь засаг захиргааны байгууллагын хавсарга маягтай ажиллаж байна, ажиллах нөхцөл нь хангалтгүй байна. Жишээлбэл, одоо ч гайгүй болж байх шиг байна, өмнө нь зарим газарт нь Засаг даргын Тамгын газрын машинд суугаад л ингээд явдаг, тэгээд багийн иргэдийн Нийтийн Хурлын даргын цалин гэж байхгүй. Багийн Засаг даргын цалингийн 30 хувьтай тэнцэх урамшуулал олгодог, багийн иргэдийн Хурлын даргад тавигдах шаардлага гэж байхгүй, ямар ч хүн гараад ирнэ. Тэр нь өнөөдөр Орон нутгийн хөгжлийн санг иргэдээс санал асууж зохион байгуулахад бол манлайлах ур чадвар

байхгүй байна гэх мэт маш олон үнэтэй саналууд гарсан байгаа. Мөн сумын Засаг даргыг иргэд шууд сонгодог байвал яасан юм бэ гэсэн санал гарч байсан. Тэр байтугай өнгөрсөн Орон нутгийн сонгуулийн хуулийг хэлэлцэх үед Р.Гончигдорж нарын гишүүдээс санаачилж боловсруулсан хуулийн төсөл овоо явж байсан тэр яагаад батлагдахгүй байна гэх ч юм уу ийм олон санал гарсан. Өөр асуулт байхгүй юу? Асуулт байхгүй бол.

Л.Цог: - Тогтоолтой холбоотой юу?

А.Бакей: - Тийм, саналаа хэлээд явчихвал яасан юм бэ? Саналтай гишүүд гараа өргөө. Л.Цог гишүүн.

Л.Цог: - Үгүй, би асуултаа татаж авлаа.

А.Бакей: - С.Баярцогт гишүүн.

С.Баярцогт: - Ажлын хэсэг сайн ажилласан юм шиг байна. Тэгэхдээ би энэ тогтоолын төсөлтэй агуулгын хувьд санал нийлэхгүй байна. Яагаад гэвэл Үндсэн хуулийнхаа зарчимтай нийцэж байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг нь эхлээд тодруулах хэрэгтэй. Манай хуулийнхан зөвлөсөн юм уу, үгүй юм уу? Яагаад гэвэл энэ чинь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага байхгүй юу. Засгийн газар үүнд зөвлөгөө өгдөг, чиглэл өгдөг тийм байгууллага ерөөсөө биш. Ганцхан зохицуулалт нь юу байдаг вэ гэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бол зөвлөмж өгдөг зохицуулалттай шүү дээ, хуулиар бол. Тэгэхээр Засгийн газарт чиглэл өгөөд Засгийн газар журам ч юм уу, үлгэрчилсэн байдлаар орон тоог нь ингэж батал гэдэг тийм эрх байхгүй. Би энэ дээр эргэлзээд байна л даа, манай Төрийн байгуулалтын байнгын хорооны хуулийн зөвлөхүүд ямар санал өгсөн юм бэ? Би санааг нь ойлгож байна. Дээрээс нь энэ 2 дугаар заалт бол ерөөсөө болохгүй, сумын Засаг даргад өмч бий болгох эрх өг гэнэ үү, би нэгдүгээр заалт дээр эргэлзэж байна, хоёрдугаар заалт бол ерөөсөө болохгүй, гуравдугаар заалт дээр зарим татваруудыг шилжүүлж гэсэн байна. Би бол үүнтэй санал нийлэхгүй. Дөнгөж аймаг дээр эрх мэдэл очиж байхад шууд залгуулаад сум руу эрх мэдэл өгнө гээд. Яагаад гэвэл Үндсэн хуулийн аймаг, нийслэл, сум, дүүрэг бол эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гэдэг бол үндсэндээ биелэхгүй байгаа шүү дээ. 21 аймгаас дөнгөж 10 нь өөрөө биеэ дагаад, 11 нь татаас авдаг энэ заалт биелэхгүй байхад сумыг үүнийг биелүүлж гэдэг ийм маягаар асуудал ярьж болохгүй. Би ажлын хэсэг сайн ажиллаад санал сайн цуглуулсан байх. Би ямар санал хэлэх гэж байна вэ гэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргах энэ тогтоолоо одоо гишүүддээ тараагаад өгчих. Гишүүд санал өгөөд дараагийн хурал дээр хэлэлцье. Жаахан бодитой юм гаргая гэж тийм л санал хэлмээр байна.

Одоо ингээд дур дураараа бид нар ийм санал гаргаад, өчигдөр Ерөнхийлөгчөөс яг энэ төсөвтэй холбоотой эрх мэдэл шилжүүлэх, зохицуулахтай холбоотой хуулийн санал орж ирсэн гээд ингээд энэ байдлаар өөрчлөгдөөд 4 дэх заалт 1.4 дээр ингээд хурлын дарга цалинжуулах, хурлын даргад шалгуур тавих гээд болохгүй байхгүй юу. Ерөөсөө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын зорилго чинь юу вэ гэхээр иргэд өөрсдөө цуглаад энэ дотроос хэн бид нарын

асуудлыг шийдэхэд төлөөлөөд явж чадах уу гээд одоо бид нар шалгуур тавина гэхээр сумын Засаг дарга бол дээд мэргэжилтэй байна гэдэг шиг шалгуур тавиад эхлэх нь байна шүү дээ. Тиймэрхүү юм руу явна, тийм учраас би үүнийгээ нэлээн сайн эргэж ярих ёстой гэж бодож байна. Хийх гэж байгаа шинэчлэлтэйгээ уялдуулах ёстой гэсэн ийм санал хэлж байна. Тэгээд үүнийг ажлын хэсэг, Байнгын хороон дарга хүлээж авах юм бол бүгдээрээ тогтоолынхоо төсөл дээр дахиж ажиллая гэсэн саналтай байна. Түүнээс яг одоо зарчмын редакцийн санал хэлээд явчихъя гэхээр болохгүй байна шүү дээ. Энэ зарчим хөндөгдөөд байгаа байхгүй юу.

А.Бакей: - Яах вэ, ер нь бол судлан шийдвэрлэх гэсэн томъёоллоор орчихсон байгаа шүү дээ. Тэгэхдээ гишүүдийн саналыг харгалзъя. Л.Цог гишүүн.

Л.Цог: - Миний асуулт байсныг С.Баярцогт гишүүн ярьчихлаа зөв л дөө. Яг суурь утгаараа ганцхан юм байгаа юм. Иргэдийн өөрөө удирдах ёсны хурлыг бид нар ингэж болохгүй, би анх зүгээр ч юм болов уу гэж бодож байсан юм А.Бакей даргыг хавар хэлэхэд бид Үндсэн хуулийг нураах юм руу орчихож байгаа байхгүй юу яг үнэн агуулгаараа. Тэрийг нь бодохгүй бол бусад нь яах вэ дээ. Тэгэхгүй бол иргэдийн Хурлын өөрөө удирдах ёсны байгууллагын даргыг Засаг даргын гар дор хийх гээд байгаа байхгүй юу. Цалин пүнлүүг нь аваад тийш нь хийгээд, шалгуурыг нь тийш нь хийгээд ингэж стандарт хийвэл алхам буруутах юм шиг байна лээ. Иймээс энэ тогтоолоо сайн үзье гэдэг зөв санал. Би үүнийг дэмжиж байна.

А.Бакей: - Сундуйн Батболд гишүүн, дараа нь Ж.Батзандан гишүүн.

Су.Батболд: - Үнэхээр Үндсэн хуулийн зарчимтайгаа уялдуулж авч үзэхгүй болохгүй. Манай энэ орон нутгийнхны яагаад байдаг юм нь бушуухан шиг төрийн халамжид орох гээд байдаг байхгүй юу. Яг төрийн албан хаагч шиг цалин хангамжтай ч юм уу, дээрээсээ удирдуулдаг, дээрээс ямар нэгэн шийдвэр ирдэг тийм юманд орчих юм бол болох гээд байгаа юм шиг. Гэтэл Үндсэн хуулийн зарчмаараа бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага чинь шал өөр байгууллага шүү дээ. Бид нарын одоо ярьж байгаа зүйлүүд, судлаачдын хэлж байгаа зүйл бол харин нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бүрдүүлэхдээ яаж бүрдүүлэх вэ, яаж улс төрөөс үл хамаарсан байх вэ, яаж иргэдийн Төлөөлөгчдийн төлөөлөл болсон тийм бүрэлдэхүүнийг бий болгох вэ гэдэг асуудал байгаа байхгүй юу. Сүүлийн үеийн юмнуудыг хараад байхаар манай Нийслэл уруу татах гэх юм уу даа, бараг Тамгын газартайгаа адилхан ингээд бүтэцтэй болоод бүр ингээд нарийвчилсан хэлтсүүдийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээрээ байгуулна гээд яваад байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын Үндсэн хуулийн тодорхойлолтоор шал өөр бай байгууллага шүү дээ. Тэгэхгүй Тамгын газартай уялдаад ингээд хамт яваад байх юм бол сүүлдээ бид нар үүнийг яаж дийлэх вэ?

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өдөр болгон ч юм уу сар болгон хуралдаад байх шаардлага байхгүй шүү дээ. Хуралдах хэрэг гарч магадгүй л дээ, гэхдээ тэгээд байх шаардлага байхгүй. иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нь угаасаа Засаг даргын Тамгын газар нь үйлчилдэг байгууллага байхгүй юу. Гэтэл би Нийслэлийг ойлгохгүй байгаа юм хэдэн хэлтэс болсныг дөрөв таван хэлтэстэй тэгээд төрийн захиргааны

ажилтнуудтай болоод тэгээд байнгын ажиллагаатай болно гээд өөрсдийгөө парламент гэж нэрлээд яваад байгаа байхгүй юу. Парламент, Хурал хоёр чинь шал өөр юм шүү дээ. Би зүгээр өөрөө нутгийн удирдлагын холбооны тэргүүний хувьд орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага яг үндсэн хуулийнхаа зарчмаар хүчирхэг тийм байгууллага байх ёстой гэдэгтэй санал нэг байдаг юм. Үүний төлөө явдаг. Гэхдээ хүчирхэг болж байгаа нь энэ гээд өөрсдийгөө төрд аваачиж тушаагаад, түүнийгээ тушаасны хүчинд төрөөс цалин пүнлүү аваад төрөөр удирдуулаад явна гэдэг бол утгагүй зүйл шүү дээ. Засгийн газрын хуульд ганцхан өгүүлбэр байгаа аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг зөвхөн удирдлага, арга зүйгээр хангана гэсэн. Түүнээс бид нар үйл ажиллагаанд нь оролцож хэзээ ч чи ингэж хурлаа хий, ингэ тэг гэж хэлдэггүй байхгүй юу. Манай энэ дүгнэлт бичсэн хүмүүс маань энэ дээр жаахан алдаатай бичсэн байна л даа. Жишээлбэл цаашид анхаарах асуудал байхгүй юу.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний Тамгын газрын ажлын уялдаа холбоог сайжруулж аливаа асуудалд нэгдсэн зорилго чиглэлтэй хамтран ажиллах гэж байгаа юм. Хэрэв Хурал, Засаг даргын Тамгын газар нэгдсэн чиг хандлагатай ажиллаад эхлэх юм бол энэ чинь өөрөө утгагүй болчихож байгаа байхгүй юу. Тэгвэл энэ хоёр байгууллага байхын хэрэг байхгүй шүү дээ. Хурал нь харин орон нутагт юу болохгүй байгаа юм бэ, юуг яаж шийдэх юм бэ гэдгийг өөрөө боловсруулаад иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдээрээ дамжуулж гаргаж ирээд Засаг даргадаа үүрэг өгөөд хэрэгжүүлдэг болохоос биш Засгийн газрын төлөөний байгууллага, төлөөний хүн болох Засаг даргын юмыг нэгдсэн зорилго чиглэлтэй ажилла гэвэл энэ чинь Үндсэн хуулийн зарчмаасаа гажуудаж байгаа байхгүй юу. Ийм юмыг бичихээр чинь сая 2012 оны сонгуулиар манай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтэц бүрэлдэхүүнийг бараг 60-70 хувь нь шинэчлэгдсэн байгаа байхгүй юу. Шинэчлэгдээд хорин жил бид нар засах гэж явж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллага гэдэг чинь ийм байгууллага шүү гэж явж ирсэн юмыг буцаагаад Засгийн газрын байгууллага мэтээр бид нар эндээс нь шахаад эхлэх юм бол нөгөө шинээр дөнгөж томилогдсон хүмүүс нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллага Засгийн газрын хавсарга байгууллага юм байна, бид нар тэндээс удирдамж чиглэл аваад явах юм байна гэсэн ийм байдлаар ажиллаад эхлэх юм бол энэ өөрөө утгагүй болж байгаа юм. Үүнийг бид нар буцаагаад засах чиглэл нь хандуулах хэрэгтэй. Тэр утгаараа энэ тогтоолын төсөл дээр хэд хэдэн юм дээр анхаарлаа хандуулъя гэж би бодож байна л даа. Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо харилцан адилгүй.

Энэ Нийслэлийн тэр халдвар аймгуудад нөлөөлж байгаа, аймгууд Засаг даргаа шахаж байгаад тийм ч хүнтэй болно гээд би аймгийн Хурлын дарга 2000 онд байсан. Би гуравхан хүнтэй ажиллаж болж байсан. Маш сайн ажиллаж байсан. Одоо Хурлууд 30 хүнтэй болоод юу хийх юм бэ, үүнийг төсөв чинь даах юм уу? Даахгүй шүү дээ. Ийм байдал руу бид нар анхаарлаа хандуулаад, бид нар энэ зүгээс нь Засгийн газарт чиглэл өгөхдөө харин яаж тэдгээрийг бие даасан Хурлын байгууллага шиг ажиллуулах ёстой юм дээр дэмжиж туслах байх жишээтэй. Тэгэхгүй төсвийн үйл ажиллагаанд санхүүжүүлэх, жишиг тогтоох, судлан шийдвэрлэх асуудлаар нь иймэрхүү өгүүлбэр байж болох юм уу даа гэж бодож байна. Ер нь миний санаа зовж байгаа юм бол аль болох Засгийн газар руу хандаад түүний хавсарга байгууллага шиг болоод байх юм бол энэ байгууллага өөрөө утгаа

алдчихаж байгаа юм.

Хоёр дахь гол юм бол энэ Нийтийн Хурлын дарга гэдэг чинь жинхэнэ сэтгэл зүрхээрээ хийдэг ажил байхгүй юу. Жинхэнэ олон нийтийн идэвхтэй тэр баг хороондоо хүмүүсийн төлөө гүйдэг ажилладаг идэвхтэй хүмүүс байдаг шүү дээ. Тийм хүнээ ажиллуулах болохоос цалинтай хүний хийдэг ажил биш шүү дээ. Хэрэв тийм хүнээ олоод Хурлын даргаар сонгочих юм бол тэр хүнд цалин пүнлүү өгөөд эхлэх юм бол нөгөө төрийн албан хаагч болчихож байгаа байхгүй юу. Өнөөдөр тэгмээр байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь би юмаа дуусгачихъя. Одоо өөр асуудал ч байхгүй, хүн ч алга байна, юмаа ярья л даа.

Тэгэхээр үүнийг би урамшууллын асуудлыг сум өөрөө шийддэг тийм байж болно. Түүнээс үүнд тодорхой шалгуур тавиад тийм хүн байх ёстой гэхгүйгээр харин ч иргэд хэнийг ч тавьж болно. Харин Су.Батболдын төлөө ч юм уу, тэнд оршин сууж байгаа Дорж, Дулмаагийн төлөө явж чаддаг, хурлыг нь хуралдуулаад багийн Засаг даргаа чангалаад байдаг, хороон Засаг даргаа чангалаад байдаг тийм идэвхтэй настай байж болно, залуу байж болно ийм хүнээ тавихад нь бид нар оролцох хэрэг байхгүй. Энэ чинь өөрөө гажуудаж байна гэсэн үг. Тийм учраас энэ дээр зайлшгүй анхаарлаа хандуулахгүй бол зөрчилтэй заалтууд яваад байна гэдгийг би хэлмээр байгаа юм. Баярлалаа.

А.Бакей: - Ж.Батзандан гишүүн.

Ж.Батзандан: - Цаг хэмнэх үүднээс хоёр асуудал дээр хоёуланд нь саналаа хэлье. Орон нутгийн асуудалтай холбоотой Байнгын хорооноос гаргаж байгаа тогтоолыг илүү боловсронгуй болгох, олон талаас нь ярилцаж байж нэлээн чамбай тогтоол гаргах нь зүйтэй байх гэдэг С.Баярцогт гишүүний гаргасан саналтай санал нэг байгаагаа илэрхийлье. Орон нутгийн эрх мэдлийг, орон нутгийн өөрөө удирдах ёсыг хүндэтгэх ёстой. Энэ бол манай ардчилсан зарчим. Тэгэхээр Үндсэн хуулийнхаа зарчимд нийцүүлсэн илүү тодорхой тогтоол байх ёстой. Нөгөө талаас орон нутгийн өөрөө удирдах ёсыг илүү боловсронгуй болгосон тийм тогтоол байх ёстой. Энэ тогтоолын төслөө хэдүүлээ олон талаас нь харж ярилцаж байж дараагийн хурлаар гаргая гэдэг санал оруулж байна.

Хоёр дахь асуудал Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хуралдах хугацаанд Байнгын хорооноос хийх ажлын төлөвлөгөөний тухайд 2 санал хэлье. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах ажлын хэсэг байгуулагдаад үндсэндээ бараг жил болж байгаа. Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаад жил болж байгаа. Сонгуулийн тухай нэгдсэн хуулийн төслийг бэлтгэх ажлын хэсэг хуралдуулах, төслийг өргөн мэдүүлэх Р.Бурмаа гишүүний ахалж байгаа ажлын хэсэг байгаа. Чухал хуулиуд байгаа. Тийм учраас энэ ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, идэвхжүүлэх, Үндсэн хуулийг дордуулсан 7 өөрчлөлтийг буцаах чиглэлд хамтдаа идэвх зүтгэл гаргаж ажилламаар байна. Хуулийн төслийг би хуульч хүний хувьд боловсруулаад бэлэн болгосон байгаа. Ялангуяа Үндсэн хуультай холбоотой Л.Цог гишүүн энэ ажлын хэсгийг бүх талаар дэмжиж Төрийн байгуулалтын байнгын хороо илүү анхаарал тавьж явмаар

байна. Иргэд олон түмний хүсэлт санал энэ чиглэлд илүү явж байгаа.

А.Бакей дарга хэлсэн, Улсын Их Хурлын гишүүд ч ярьж байгаа. 18 сайдтай Засгийн газар Улсын Их Хурлынхаа толгой дээр гарчихлаа. Засаглалыг хуваах зарчим, үзэл санаа алдагдчихлаа. Улсын Их Хурал нь тоглоомын байгууллага шиг болчихлоо гэж одоо үүнийг өөрчлөх цаг болсон. Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага юм бол бид парламентад ёсыг сонгосон юм бол энэ чиглэлдээ Үндсэн хуулийн өөрчлөлтөө хийгээд эрх зүйн шинэчлэлээ хийгээд явах нь зүйтэй. Тэгэхээр энэ ажлын хэсгүүдийг эрчимжүүлж гэдэг саналтай байна. Энэ намрын чуулганаар энэ асуудлыг нухацтай авч хэлэлцье.

Л.Цог: - А.Бакей дарга юм асуух уу? Анх та хэлэхдээ хавар ингэж ойлгуулсан шүү дээ. Орон нутгийн Хурлыг арга зүйн технологиор хангах энэ юу орхигдсон байдаг юм байна. Үүнийг хаана байхыг шийдэх тийм хэсэгтэй гэж ингэж ойлгосон чинь тэр явсаар байгаад ийм болчихсон юм уу? нэг.

А.Бакей: - Би дараа хариулт өгье, тэр тусдаа.

Л.Цог: - Хоёрдугаарт тэр Ж.Батзандан гишүүний хэлдэг маш чухал асуудал. Ухаан нь тэр Үндсэн хуулийг өөрчлөх шаардлага байгаа эсэх асуудал манай комисс энэ Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль гэдэг нь энэ хуулийг өөрчлөх тухай асуудал. Сонгуулийн нэгдсэн хууль батлах тухай гурван ажлын хэсгийг яаралтай хөдөлгөхгүй бол шүүмжлэлд өртөхөөс гадна нийгэм болохгүй байна гэдгийг харуулж байна. Энэ утгаараа Ж.Батзандан гишүүний саналыг дэмжиж байгаа юм. Манай Байнгын хороо анхааралдаа аваад болох болохгүй юм зөндөө байна л даа. Эвээ олъё л доо яаж ийгээд.

А.Бакей: - Х.Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: - Яг энэ асуудалтай холбоотой сая Л.Цог гишүүн бас хөндчихлөө, 2 асуудал байна. Үндсэн хуулийнхаа үзэл баримтлал нутгийн өөрөө удирдах ёсны цаана байдаг онол гэдэг юм уу, эсвэл уг концепцтой нь зөрчилдөхгүй юм хийхгүй бол нэг болохоор нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг Засгийн газар аваачиж наах гээд байдаг, нэг болохоор Улсын Их Хурал руу авчирч наах гээд байдаг тийм юм байж ерөөсөө болохгүй. Жишээ нь Улсын Их Хурлаас зөвлөмж чиглэл өгдөг үүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг тийм бүтцийг Улсын Их Хурал дээр бий болгоё гээд бараг таны санаачилсан хууль Засгийн газар дээр санал авах гээд явж байна лээ.

Улсын Их Хурал бол хууль тогтоодог байгууллага. Нутгийн өөрөө удирдах ёс бол зүгээр тэнд оршин сууж байгаа иргэдийн өөрсдийн community байхгүй юу тухайн нутгийн. Энэ хоёрыг хольж ерөөсөө болохгүй. Хольж буруу ойлгосноос болоод Үндсэн хуулийн цэц дээр маргаан гарсан байхгүй юу. Юу гарсан бэ гэхээр нутгийн өөрөө удирдах байгууллагын дээд байгууллага гээд Улсын Их Хурлыг заах гэж оролдоод байсан байхгүй юу. Энэ чинь байж болохгүй байхгүй юу. Энэ чинь өөрөө дээрээ байгууллага байдаггүй тэнд амьдарч байгаа хүмүүсийн өөрийн удирдлагын байгууллага болохоос биш дээр нь ямар нэгэн байгууллага байдаг тийм

бүтэц ерөөсөө биш. Улсын Их Хурал руу авчирч наах гэхээр яг энэ буруу ойлголт адилхан Хурал гэж хараад энэ чинь Улсын Их Хурал орон нутагтаа энэ нь юм байна гээд таны саяын Су.Батболд гишүүн хэлчихлээ, Нийслэл өөрөө парламент гэдэг юм руу орох гэж байгаа байхгүй юу, биш. Хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдана. Төлөөллийн маягийн ардчиллын систем чинь унитар улсад ганцхан байх ёстой байхгүй юу. Үүнийг задлах гэж оролдох юм бол энэ өөрөө Үндсэн хуулийн эсрэг, тэр битгий хэл Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг болж хувирна. Тэгэхээр орон нутагт хууль тогтоох эрх мэдэл өгөх гэж байгаа юм шиг, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг өөрөө өөрийнхөө нутаг дэвсгэр дээр хуулийн хэмжээнд тогтоох тийм тусгаар холбооны улсын статустай байх хэмжээний юм шиг тийм санаачилгыг Улсын Их Хурал ерөөсөө гаргаж болохгүй. Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооноос тийм буруу хандлагаар явж байгаа юмнуудаа зогсоох ёстой.

Энэ бол зүгээр өөрөө удирдах ёсны байгууллага иргэд тэндээ хуралдаад дотоод асуудлаа шийдээд, тэр нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид харшлахгүй бол шийдвэр гаргах эрх мэдэлтэй, тэр нь хажууд байгаа Засаг даргад чиглэл өгөөд өөрсдөө үйлчлүүлэх гэхдээ хөнжлийнхөө хэрээр хөлөө жий гэдэг шиг өөрсдийнхөө олж байгаа орлого дотор хэмжих болохоос биш бусдын мөнгийг зараад Засгийн газар чиглэл өгөөд хууль тогтоох эрх мэдлийг аваад явдаг тийм схем ерөөсөө байж болохгүй байхгүй юу. Үүнийг нэг талаасаа харах ёстой. Хоёрдугаарт нь саяын Су.Батболд гишүүн хэлчихлээ Засгийн газарт нааж авчраад захиргааны байгууллага болгож ерөөсөө болохгүй. Өөрөө удирдах ёсны байгууллага чинь иргэний нийгмийн байгууллага гэж үзээд байгаа шүү дээ, дэлхий нийтээрээ, иргэний нийгмийн байгууллага гэхдээ дотооддоо шийдвэр гаргаж байгаа учраас нийтийн эрх зүйн статустай шийдвэрүүд нь захиргааны шүүхэд хянагдана. Байгууллага нь өөрөө иргэний нийгмийн байгууллага захиргааны байгууллага биш шүү, төрийн байгууллага биш шүү. Энэ өөрөө удирдлагын иргэдийн байгууллага шүү гэж хэлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн философио ойлгоод бид нар энэ тогтоолтой холбоотой энэ дээр ярьж байгаа бүх юм чинь өөрөө Үндсэн хуулийнх нь үзэл санааны эсрэг юм явж байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийгээ эргэж нэг хараад бараг нь энэ тогтоол байх ёстой юм уу, үгүй юм уу би бол бараг эргэлзэж байна.

А.Бакей: - Ингээд болсон уу?

С.Баярцогт: - Яах вэ, би парламентынхаа гишүүдэд Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой зүйл дээр дордуулсан 7 өөрчлөлт гэж ярьдгаа парламентын гишүүд өөрсдөө болих хэрэгтэй. Үндсэн хуулийн өөрчлөлт гэж ярьж сур. Дордуулсан 7 гээд байгаа дотор чинь парламентат ёсыг бэхжүүлсэн хоёр гурван заалт байгаа байхгүй юу. Тэгэхээр өөрсдөө тэрийгээ мэдэж байгаа, бид нар амьдралаа мэдсэн учраас Ерөнхий сайдаа томилж чаддаггүй, Ерөнхийлөгчөөс хараат тийм Үндсэн хуультай байсан байхгүй юу. Тэрийг өөрчилсөн байхгүй юу. Парламент нь 66 хувийн ирцтэй хуралддаг тэрийгээ өөрчилсөн байхгүй юу гэх мэтчилэнгийн олон зүйл байгаа. Мэдээж хүмүүст таалагдахгүй тэр чинь эрхийг нь нээсэн нээлт байгаа шүү дээ. Парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байж болно. Парламент өөрөө хязгаарлаж болно шүү дээ, гуравны нэг нь байж болно, эсвэл зөвхөн Ерөнхий сайд

нь байж болно. Тэр нь эрх нь парламентад байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг тэр хийсэн өөрчлөлтийг бид нар дотроо дордуулсан 7 өөрчлөлт гэж бид нар яриад учраас ард түмэн тэгж ойлгоод байгаа байхгүй юу. Түүнээс нэгэнт хуулийн дагуу хийгдчихсэн өөрчлөлт учраас тэр өөрчлөлт гэж ярьж сурч байж цаашаа юмнууд явах нь зүйтэй гэж би тэгж бодож байна. Баярлалаа.

Л.Цог: - Би саналаа хэлэх үү?

А.Бакей: - Та дахин дахин хэлээд байх юм.

Л.Цог: - Би эсрэг саналтай байгаа. Яах вэ, С.Баярцогт гишүүн ажлын хэсэгт нь орсон түүх байдаг юм л даа. Монголын түүхэнд ингэж Үндсэн хуулиа хулгайн замаар нураасан, эрх мэдлээ хольсон, өнөөдөр хүртэл засаж чадахгүй байгаа ийм юм ахиж битгий таараасай гэж боддог байхгүй юу. Хамгаалж өмгөөлөх нэг ч заалт байхгүй. Долуулаа дордсон, айх ч хэрэггүй.

А.Бакей: - Р.Гончигдорж гишүүн, дараа нь Р.Бурмаа гишүүн. Ингээд санал дууслаа.

Р.Гончигдорж: - Манай ажлын хэсэгт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцаад дүнг хэлэлцэж байна л даа. Мөн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн чиг үүрэгтэй, бүрэн эрхтэй үйл ажиллагааны зарчимтай. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргатай харилцах харилцааны асуудлууд нэлээн тодорхой байдаг. Одоо харин бид нар шинэ зүйл рүү орох тэр чиглэлд нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тэр чиглэлд нь ажиллахад нь хууль эрх зүйн болон Үндсэн хуулийн хүрээнд тодорхой чиг үүргүүд өгч болох юм. Өнөөдөр бид нар шууд ардчилал гэж ярьж байна шүү дээ. Өөрөөр хэлбэл иргэний оролцоогоор иргэд шууд шийдвэрээ гаргахад оролцоо оролцоог яаж хангаж бий болгох вэ гээд. Миний ойлгож байгаагаар Улсын Их Хурлаас тодорхой төсөл UNDB /Нэгдсэн Үндэстний Байгууллага/-ын юм уу, тийм төсөл хэрэгжиж байгаа гэж ойлгож байгаа тийм биз. Ерөнхийлөгчийн Тамгын газар юм уу, өөрөөр хэлбэл бид нар энэ иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа энэ чиглэлд ажиллах мэргэжлийн чадавхыг бий болгох, мэргэжил арга зүйн удирдамж чиглэлээр хангах энэ чиглэл дээр ажиллах ажиллагаа нь бол хамгийн чухал нь байгаа гэж ингэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл тэднийг түрүүн хэллээ шүү дээ, гишүүд хэлээд байна. Энэ бол иргэдээсээ сонгогдоод тухайн нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж дэх хуульд нийцсэн өөрийн онцлогийг харгалзсан тодорхой шийдвэрүүдийг гаргаж Засаг даргаар хэрэгжүүлж түүнд хяналт тавих энэ чиг үүрэг дээр. Тэгэхээр зэрэг энд одооны шинэчлэлийн асуудал нь иргэдийн оролцоог яаж хангах вэ, иргэдийн төлөөлөгчид бүх юмыг шийдэх үү, иргэдийн төлөөлөгчид бүх асуудлыг шийдэхдээ иргэдийн оролцоог заавал оролцуулж хангаж байж ингэж ажиллах чиглэлд нь нутгийн өөрөө удирдлагын байгууллагынх нь хувьд.

Нутгийн өөрийн удирдлага гэхээр зэрэг иргэд өөрөө өөрийгөө удирдах гэдгийг төлөөлөн удирдаж байгаа институт байж байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг иргэд өөрөө өөрсдөө удирдах тэр чиглэл рүү илүү дэлгэмэл болгохын тулд энд ямар зүйл ажиглагдаж байна вэ, хэрэгтэй байна вэ, шаардлагатай бол энд нэг заалт байгаа л

даа. Монгол Улсын засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Улсын Их Хурлын ээлжит чуулган руу өргөж мэдүүлэх гэсэн ийм асуудал. Энэ нь энд байх чухал заалт байх гэж бодож байгаа манай Төрийн байгуулалтын байнгын хороо. Тэр үзэл баримтлал нь миний саяын хэлсэн тэр үзэл санааны дагуу цаашид хийгдэх нь зүйтэй байх гэсэн ийм байдал.

Өөр нэг байдал нь бол мэдээж хэрэг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бие даасан байдлаа хангахын тулд төсөв нь бие даасан байдлыг нь хангахад хүрэлцэхүйц хэмжээтэй байх тухай асуудал. Тэгээд үйл ажиллагаагаа явуулах тэр нөхцөл байдал нь өөрөө Засаг даргын Тамгын газраас хамааралгүйгээр өөрсдөө хараат бусаа явж чадах тэр орчин нөхцөлөөрөө хангагдсан байх ийм чиглэлүүдийг нь анзаарсан, энэ чиглэл дээрээ тогтоолоо гаргавал зүйтэй болов уу. Манай танилцсан гишүүд ч гэсэн энэ дээр нь нэлээн дутмаг зүйлүүд байгааг харсан байх гэж бодож байна. Баярлалаа.

А.Бакей: - Р.Бурмаа гишүүн.

Р.Бурмаа: - Энэ дээр гишүүдийн тогтоол хойшлуулъя гэсэн саналтай нэг байна, судалъя. Энэ ямар асуудлыг Засгийн газраас хуулийн төсөл оруулж ирэх, ямар асуудал дээр Их Хурал өөрөө илүү анхаарч ажиллах вэ гэдгийг анхаарах хэрэгтэй байна. Жишээ нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагатай холбоотой хуулийн төслийг санаачлах ажлыг тэр тусмаа Их Хурал, Их Хурлын энэ Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулаад ажиллуулна уу гэхээс биш, Засгийн газарт даалгаад энэ Төлөөлөгчдөөс гаргасан орон нутагт ажиллаж байгаа нутгийн захиргааны байгууллагад ажиллагсад гаргасан саналыг судалж үзээд хуулийн төслийг боловсруулж оруулж ирье гэдэг даалгавар өгдөг нь буруу гэж бодож байна л даа. Тэгэхээр нэгэнт ажлын хэсэг эндээс Төрийн байгуулалтын байнгын хорооноос явж уулзаж иргэдээс санал авсан юм бол шаардлага гарах юм бол ажлын хэсгээ байгуулаад тэгээд энэ хуулийн төслөө боловсруулна уу гэхээс биш Засгийн газарт өгөөд Засгийн газар руу нутгийн өөрөө удирдах байгууллагын асуудлыг аваачиж өгөөд байдаг нь буруу гэж бодож байна.

Хоёрт энэ төрийн болон төсвийн удирдлагын төвлөрлийг сааруулах шинээр сонгогдсон, томилогдсон албан тушаалтнуудыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө гарган ажиллах гээд. Энэ дээр бид нар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүдийг төлөөлөгчдийг мэргэшүүлэх төслийг чинь Их Хурал дээр байх ёстой гээд бид нар авсан шүү дээ. Тэгээд ер нь мэргэжил арга зүйн талаараа сургалт хийх, ажиллах гэдэг энэ чиглэлээрээ Их Хуралтайгаа холбоотой байх нь илүү дээр болов уу гэж бодох юм. Үүнийг аваачаад Засгийн газар дээрээ буцааж аваачаад юм болгоныг ингээд байдаг нь болохгүй байх гэж бодоод байна. Тийм учраас өмнөх гишүүдийн хэлснээр тогтоолын төслийг эргэж судлах нь зүйтэй байх.

Су.Батболд: - Чухал асуудал ярьж байгаа учраас би хоёрхон зүйл дээр санал хэлье гэж бодож байна. Ер нь бол ийм шүү дээ. Р.Гончигдорж дарга юу гэж бодож байгаа юм, би бол шууд Монгол Улсын Үндсэн хуульд бид нар төлөөллийн ардчилал

байгаа байхгүй юу. Одоо бид нар төлөөллийн ардчиллаа төлөвшүүлж чадаагүй үүнийхээ асуудлаар будлиад болж явна л даа. Тэр үедээ шууд ардчиллын тухай яриад ялангуяа Швейцарийг жишээ болгоод байгаад би буруу гэж боддог байхгүй юу. Олон үндэстнээс бүрдсэн бараг нь тосгон болгонд нь өөрөө удирдах ёсны асуудал тэгээд холбоотой маягийн тийм community тогтчихсон тийм улстай бид нар шууд ардчиллын тухай яриад бүх юмыг сумын 2500 иргэн цуглаж байж шийднэ гэдэг тийм байдлаар асуудлыг ярих нь Үндсэн хуулийнхаа төлөөллийн ардчиллын эсрэг ярьж байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр яах вэ, мэдээж иргэдийн оролцооны тухай асуудал дэлхий нийтээр чухал зүйл болж байгаа юм. Энэ ямар хэмжээнд байх вэ гэдгийг бид нар ярихгүй бол хүн болгон шууд ардчиллын тухай яриад байх юм бол нөгөө Үндсэн хуулиар тунхагласан төлөөллийн ардчилал, энэ парламент бусад юмнууд чинь хүнд байдалд орно шүү дээ. Би Үндсэн хуулийн зарчмаа бодож ярьж байхгүй бол ялангуяа улс төрчид, улс төрийн намууд үүнийг хэтэрхий хөөрцөглөх нь бас буруу зүйл рүү хүргэж болзошгүй юм. Мэдээж иргэний нийгмээрээ дамжуулаад бусад олон салаа мөчрөөрөө дамжуулаад хэдэн саналыг авах асуудал бол нээлттэй байгаа. Манайд харьцангуй иргэний нийгмийн хөгжил сайн байгаа.

Хоёр дахь юм бол ийм юм байгаа юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх өөрөө удирдах ёсны байгууллага байгаа байхгүй юу Х.Тэмүүжин сайдаа тийм ээ? Тэгэхээр яг энэ засаг захиргаа нутаг дэвсгэр өөрөө удирдах ёсны байгууллага, парламент, Засгийн газар гурвын хоорондын харилцааг маш зөв олж тогтоохгүй бол энэ ерөөсөө Засгийн газарт хамаагүй, эсвэл энэ нь ерөөсөө парламент энд ямар нэгэн байдлаар хутгалдах ёсгүй гэсэн байдлаар хандах юм бол энэ өөрөө өрөөсгөл болчихно. Харин хууль тогтоож хандана. Бид нар хууль тогтоох эрхийг нь парламентын гишүүд Байнгын хороо аваад хэрэгжүүлж болно. Гэхдээ ингэхгүй бол магадгүй нөгөөдөх маань бид нарын яриад байгаатай адилхан өөр тийшээ яваад байгаа байхгүй юу. Нэг бол холбооны улсын маягийн хурал шиг болох гээд байдаг ч юм уу, эсвэл Засгийн газрын харьяа байгууллага болчих гээд байдаг, эсвэл парламенттай адилхан эрх мэдэлтэй гэсэн байдлаар хандах гээд байдаг ийм юм гараад байгаа учраас энэ дээр Төрийн байгуулалтын байнгын хороо нэгэнтэй та нар судлаад үзсэн нь сайн байна. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хувьд манай нутгийн өөрөө удирдлагын холбоотой хамтарч судалгаа хийж байгаад энэ дээр яаж хандах ёстой юм бэ гэдэг дээр анхаарлаа хандуулж дүгнэлт гаргах нь зүйтэй байх гэж бодож байна. Тэр утгаараа тогтоолын төслөө нэлээн сайн боловсруулж байгаад бусад олон нийтийн байгууллага ч юм уу бусад газраас санал авч байгаад ингээд боловсруулвал зүгээр юм уу гэж бодож байна.

А.Бакей: - Баярлалаа.

Л.Цог: - Ганцхан юм, энэ их чухал асуудал ярьж байгаа юм.

А.Бакей: - Уг нь бол их чухал асуудал л даа. Тэгээд та бүхэн өгүүлбэр болгоны цаана нарийн асуудал байгаа шүү.

Л.Цог: - Энгийн юм шиг мөртлөө, тэр чинь 2 талтай. Би Су.Батболд гишүүний хэлж байгааг дэмжих гээд байгаа байхгүй юу. Өнөөдөр Монголд ноднингоос шууд ардчиллыг нээчихсэн юм шиг ингэж ярьдаг түмэн буруу, туйлын буруу. Энэ чинь

хэдэн зуун жилийн түүхтэй юм шүү дээ, хүн үүссэн цагаас эхлээд шууд, төлөөллийн ардчилал гээд явсан шүү дээ. Өнөөдөр гэтэл Ц.Элбэгдорж гэнэт нээчихсэн юм шиг энэ хавар баахан ярьсан. Тэр нь улс төрийн том алдаа болсон, болохгүй. Хоёрдугаарт, Монгол Улс нэгдсэн улс унитарный Үндсэн хуульд зааж, үүнийг алдах тухай бид ярьж болохгүй байхгүй юу. Хязгаарыг сайн ярихгүй бол үнэхээр болохгүй боллоо. Жин панг нь тааруулахгүй бол Үндсэн хуулийнхаа эсрэг юм болж хувирна шүү гэж бодож байгаа.

Р.Гончигдорж: - Шийдвэр гаргах эрх мэдлийн агуулгаасаа оролцооны эрх боломжоо хангуулах гэдэг тэр томъёоллоор нь илүү ойлгох ёстой. Шийдвэр гаргах эрх мэдлийн тухай асуудлаар биш оролцоогоо хангах оролцоог нь хангах тэр эрх мэдлийг нь дэглэх тухай асуудлаар ойлгох ёстой юм. Түүнээс шийдвэр гаргах гэвэл мэдээж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр, багийн хурал дээр бид нар мэдэж байгаа шүү дээ. Багийн хурал бол шууд багийн Нийтийн хурлаар багийн асуудлыг шийддэг. Энэ чинь үнэн хэрэг дээрээ яг нийт оролцоо байхгүй. Гэтэл багаас бүрддэггүй сум гэж байхгүй тийм биз. Асуудал нь баг дээр гүйцэтгэгдэж зохион байгуулагддаг тийм үйл ажиллагаа гэж байхгүй шүү дээ. Тийм учраас энэ багийн хурлаар дамжсан тэр оролцоо болон тодорхой асуудлаар иргэний оролцоог хангасан. Тэр шийдэл заавал биелүүлэх шийдвэрийн хэмжээнд шийдвэр гаргагч байгууллагын гэдэг тэр ойлголтоор нь биш байхаар л ингэж зөв зохистой аваад явах шаардлагыг л яриад байгаа юм миний ойлгож байгаа ойлголт.

А.Бакей: - Гишүүд саналаа хэлж дууслаа. Тэгэхээр энэ бодит байдал дээр яг орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу өөрийгөө удирдах байгууллагын ажиллах нөхцөл байдал бол огт хангагдахгүй байгаа юм байна лээ. Үндсэндээ орон нутгийн засаг захиргааны хавсарга, Засгийн газрын хавсарга ийм байдлаар тэгсэн мөртлөө та нар өөрсдөө ажиллах ёстой гээд зөнд нь орхичихоор огт ажиллаж чадахгүй, өнгөрсөн 23 жилийн турш бол зүгээр хавсарга маягтай явж ирсэн. Үүнийг бид нар хүлээн зөвшөөрөх ёстой. Өөрөөр хэлбэл төсвийн бие даасан байдал байхгүй нөхцөлд бол ямар ч арга байхгүй байна шүү дээ. Жишээлбэл өнөөдөр тодорхой санал орон нутагт төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, орон нутгийн Засаг даргыг томилоход санал өгөх, огцруулахад санал өгөх байгууллага мөртлөө хавсарга нь байгаад байгаа байхгүй юу. Сангийн яам нь болохоор бүх төсвийг хасаад хаячихдаг. Би тэгээд хэлж байна, тэгсэн мөртлөө орон нутагт иргэний танхим гээд байгуулагдчихсан байна. Тэр нь ямарваа нэг хууль эрх зүйн ямар ч орчин, статус байхгүй. Тэгсэн мөртлөө иргэний танхимын дэргэд байгуулагдаад тэр нь үйл ажиллагаа явуулаад байдаг. Тэгэхээр энэ дээр гарцаагүй ийм тогтоол шийдвэр гарах ёстой. Тэгэхдээ заавал өнөөдөр гаргуулах гээд зүтгэх шаардлага байхгүй гэж бодож байна. Судлах нь зүйтэй тал талаасаа.

Энэ дээр нэг жишээ хэлэхэд аймгуудыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын орон тоо, төсвийг судлаад үзсэн байхгүй юу. Маш харилцан адилгүй. Жишээлбэл Хөвсгөл аймаг бол хамгийн хүн амтай аймаг шүү дээ. Гэтэл иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын орон тоо нь ердөө тавхан хүнтэй 197 сая төгрөгтэй. Гэтэл Дундговь аймаг хамгийн бага хүн амтай аймгийн тоонд орж байгаа шүү дээ, 15 хүнтэй орон тоотой төсөв нь 300 сая. Ийм харилцан адилгүй юм бий болоод байгаа байхгүй юу.

Энэ дүүрэг мөн адилхан байна. Жишээлбэл Баян болохгүй, тэгэхээр үүнийг бид нар тэглэж болохгүй ч гэсэн хуулийн ямар нэгэн зохицуулалт байхгүй болохгүй болчихоод байна л даа. Өөрөө шийдлээ ч гэсэн ингэж шийдэж болох юм уу, үгүй юм уу гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу. Тийм л дээ, тэгэхээр ийм маягаар судлах олон асуудал байна. Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төв гэж байгаа. Тэр нь бол аймгуудад огт ажиллахгүй байгаа. Өнөөдөр хууль хэрэгжихгүй байгаагийн нэг шалтгаан бол энэ төвүүд маань ажиллаж байна уу, үгүй юу бас байхгүй. Нөгөө иргэний танхим нь эрх зүйн статус байхгүй, ингээд тал тийшээ харсан ойлгомжгүй асуудал орон нутагт бий болоод байгаа шүү. Тийм учраас Их Хурлын гишүүдийн зүгээс гарсан саналыг дахиж ажлын хэсэг сайн судалж үзээд, мэдээж Үндсэн хуулиас давсан тогтоол хэзээ ч гарахгүй л дээ. Хамгийн гол нь энэ асуудлын энд оруулж хөндсөн санал нь дандаа асуудал байгаа шүү. Үүнийг эрхэм гишүүд сайн ойлгоорой. Тэгээд ямар ч байсан дараагийн хурал ч юм уу, түүний дараагийн хурал дээр дахиж хэлэлцье. Энэ асуудлыг ингээд шийдье.

Дараагийн асуудал.

Гурав. Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хорооноос хийх ажлын төлөвлөгөөний тухай.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос хийх ажлын төлөвлөгөөг та бүхэнд тараасан байгаа. Миний ойлгож байгаагаар сая Ж.Батзандан, Л.Цог гишүүн тодорхой санал гаргалаа. Энэ саналыг илүү тодруулж тусгая. Энэ дашрамд хэлэхэд бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх асуудлаар үндэсний багаас бүрдсэн тодорхой судлаачид бүрдсэн судалгаагаа хийж байгаа. 12 сарын эцэс гэхэд энэ судалгааны эцсийн дүн гарна. Тэр үед үүнийг бид тодорхой хэлэлцэнэ. Ер нь бол гурван ажлын хэсэг Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай ажлын хэсэг байна, Үндсэн хуулийн ажлын хэсэг байна. Энэ гурван ажлын хэсгийн ажиллах хугацааг Улсын Их Хурлын даргын шийдвэрээр дахиж сунгасан байгаа. Нэлээд нухацтай ажиллах ёстой, тэгэхдээ ажлыг эрчимжүүлэх ёстой гэдэгтээ санал нэг байна. Үүнийг бид зохион байгуулна. Энэ дашрамд ирэх нэг дэх өдрийн Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль, мөн Сонгуулийн тухай хуулийн хамтарсан ажлын хэсгийн хурал болно. Үүгээр сонгууль болоод улс төрийн намын санхүүжилтийн асуудлаар ажлын хэсгийн хүрээнд нэлээд хэлэлцүүлэг явуулна. Үүний дагуу бид тодорхой сэдэвчилсэн хэлэлцүүлэг явуулахаар ажлын төлөвлөгөөнд тусгая. Ингээд өөр санал байхгүй бол энэ ажлын төлөвлөгөөг дэмжих үү? Дэмжиж байгаа гишүүд гараа өргөө?

Ажлын шугамаар та хэлчих. Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Төлөвлөгөөг бүрд баталсан уу?

12-оос 8. Эрхэм гишүүдэд баярлалаа.

Соронзон хальснаас буулгасан:

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ

ШИНЖЭЭЧ

М.НОМИНДУЛАМ

